# БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ
# ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

БАЙГУУЛЛАГЫН НЭР:
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

БАТАЛГААЖУУЛСАН: ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

..................................Б.ЗОРИГТБАЯР

Тэмдэг ..................................
(огноо)

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА

..................................Ж.БААСАНСҮРЭН

НЭГТГЭЖ ТАЙЛАГНАСАН:
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА

..................................Ц.ЭРДЭНЭЧИМЭГ

Тэмдэг 2024.12.05..........
(огноо)

4391403 2024010011 БТ00532

ОРХОН АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД

ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

2024-12-30

Орхон аймаг

| Д/Д | Зорилт / Үнэлгээ | Бүгд | Гүйцэтгэлийн зорилт 1 | Гүйцэтгэлийн зорилт 2 | Гүйцэтгэлийн зорилт 3 | Гүйцэтгэлийн зорилт 4 | Гүйцэтгэлийн зорилт 5 | Гүйцэтгэлийн зорилт 6 | Гүйцэтгэлийн зорилт 7 | Гүйцэтгэлийн зорилт 8 | Гүйцэтгэлийн зорилт 9 | Гүйцэтгэлийн зорилт 10 | Гүйцэтгэлийн зорилт 11 | Гүйцэтгэлийн зорилт12 | Гүйцэтгэлийн зорилт 13 | Гүйцэтгэлийн зорилт 14 | Гүйцэтгэлийн зорилт 15 | Гүйцэтгэлийн зорилт 16 | Гүйцэтгэлийн зорилт 17 | Гүйцэтгэлийн зорилт 18 | Гүйцэтгэлийн зорилт 19 | Гүйцэтгэлийн зорилт 20 | Гүйцэтгэлийн зорилт 21 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээний тоо | 75 | 5 | 2 | 1 | 4 | 3 | 5 | 1 | 2 | 2 | 4 | 3 | 4 | 5 | 4 | 6 | 5 | 2 | 2 | 4 | 7 | 4 |
| 2. | 6.2.1 буюу 100% ба түүнээс дээш | 61 | 4 | 2 | 1 | 2 | 2 | 3 | 1 | 2 | 2 | 4 |  | 4 | 5 | 4 | 4 | 5 | 1 | 2 | 4 | 5 | 4 |
| 6.2.2 үүнээс | 98.4% | 1 |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1 |  |  |  |  |  |  |  |  |  |  |
|  | 98.3% | 1 |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1 |  |  |  |  |
|  | 90.0% | 8 |  |  |  | 1 |  | 1 |  |  |  |  | 2 |  |  |  | 2 |  |  |  |  | 2 |  |
|  | 82.1% | 1 |  |  |  |  |  | 1 |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |
|  | 70.0% | 1 | 1 |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |
|  | 50.0% | 1 |  |  |  |  | 1 |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |
|  | 30.0% | 1 |  |  |  | 1 |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |
| Ерөнхий үнэлгээ, хувь |  | 96.6% буюу 4.83 оноо | 94% буюу 4.7 оноо | 100% буюу 5.0 оноо | 100 % буюу 5.0 оноо | 80% буюу 4.0 оноо | 83.3 % буюу 4.2 оноо | 94.4 % буюу 4.72 оноо | 100% буюу 5.0 оноо | 100% буюу 5.0 оноо | 100% буюу 5.0 оноо | 100% буюу 5.0 оноо | 92.8 % буюу 4.64 оноо | 100% буюу 5.0 оноо | 100% буюу 5.0 оноо | 100% буюу 5.0 оноо | 96.6 % буюу 4.83 оноо | 100% буюу 5.0 оноо | 99.1 % буюу 4.95 оноо | 100 % буюу 5.0 оноо | 91.4 % буюу 4.57 оноо | 97.1 % буюу 4.85 оноо | 100 % буюу 5.0 оноо |

ХЯНАСАН: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Б.ЗОРИГТБАЯР

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН : ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА Ж.БААСАНСҮРЭН

**ОРХОН АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН**
**2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**
**/БҮТЭН ЖИЛИЙН БАЙДЛААР/**

**НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратеги төлөвлөгөөний зорилго-1.1: ӨМЧИЙН УДИРДЛАГА, ХЯНАЛТ ШАЛГАЛТ**<br>**Орон нутгийн өмчит байгууллагуудын өмчийн удирдлагад хяналт тавьж, бүрэн бүтэн байдлыг хангуулах зарчимд тулгуурласан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах** | | | | | | | |
| 1.1 | ЗОРИЛТ-1: Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өмчийн удирдлага, санхүүгийн үйл ажиллагаа, эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад хяналт шалгалт хийх. | | | | | | |
| 1.1.1 | Арга хэмжээ-1:<br>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлого, чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, хууль тогтоомжийг сурталчлан таниулах, өмчийн харилцааны асуудлаар орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан хаагчдыг мэргэжил, арга зүйгээр хангах | Байгууллагын төсвөөр | Журмын төсөл боловсруулж батлуулсан байна.<br>Мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн албан хаагчийн тоо | - | Журмыг батлуулж орон нутгийн өмчит байгууллагуудад аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулах, сургалт зохион байгуулах | Орон нутгийн өмчийн газраас санаачлан Орхон аймгийн орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлагуудад зориулсан Компанийн засаглалын сургалтыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлага, төлөөллийн албаны дарга В.Дарханбаатар, мэргэжилтэн А.Молор, Б.Амарбаясгалан, Г.Нямдаваа нар 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад орон нутгийн өмчит "Эрдэнэт Ус, дулаан түгээх сүлжээ" ОНӨХК, "Жаргалант Ус, дулаан түгээх станц" ОНӨХК "Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн парк" ОНӨААТҮГ, "Хот байгуулалт, барилга захиалагчийн алба" ОНӨААТҮГ, "Гэр бүлийн ордон" ОНӨААТҮГ, "Их шүтээн цогцолбор" ОНӨААТҮГ, Мэдээлэл шуурхай удирдлагын төв, Нийтлэг үйлчилгээний алба, Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар, Хот тохижуулах газар, "Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн" АӨЗ-ны гүйцэтгэх удирдлага, төлөөлөн удирдах зөвлөлийн 43 | 100<br>100 |

43

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гишүүн.хамрагдсан. | |
| 1.1.2 | Арга хэмжээ-2: Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өмчийн удирдлага, санхүүгийн үйл ажиллагаанд баримтын хяналт шалгалт хийх | Байгууллагын төсвөөр | Баримтын шалгалтад хамрагдах хуулийн этгээдийн тоо | - | Төлөвлөгөөний биелэлт, танилцуулга, цаашид авах арга хэмжээ, арга хэмжээний үр дүнг гаргасан байна. | Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдэд үндсэн 4 чиглэлээр:<br>1.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмшил, түүний бүртгэлд хяналт тавих;<br>2.Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд хяналт шалгалт хийх, улсын бүртгэлд бүртгүүлэхэд бэлтгэл хангах;<br>3.Тээврийн хэрэгслийн бүртгэлд хяналт тавих;<br>4.Байгууллагын нярвын үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт тавих ажлын төлөвлөгөөг байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлээр 7 хэсэгт хуваах, хяналт шалгалт хийхээр төлөвлөсөн.<br>Хяналт, шалгалтын удирдамж болон хяналтын хуудас боловсруулсан.<br>Хяналт, шалгалтыг 2024 оны 7 дугаар сараас эхлэн төлөвлөгөөний дагуу орон нутгийн өмчит байгууллагуудад системийн хяналт, шалгалтыг хийж хэрэгжилтийг хангаж ажиллалаа.<br>Соёлын чиглэлийн 9 байгууллагад Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам, байгууллагын эд хөрөнгийн тооллогын хэрэгжилтийн талаарх хяналт, шалгалтыг Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын албан хаагчдын хамт явуулж, дүгнэлт, санал боловсруулан ажиллаж байна.<br>Орон нутгийн өмчийн газрын хөрөнгийг ашиглалтын гэрээгээр ашиглаж байгаа байгууллагуудад хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад дотоод хяналт, шалгалтыг хийж, гарсан зөрчлийн талаар хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан. | 70.<br>70 |

44

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.3 | Арга хэмжээ-3: Орон нутгийн өмчит төсөвт байгууллагуудын өмчийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтад системийн хяналт шалгалт хийх | Байгууллагын төсвөөр | Шалгалтад хамрагдах хуулийн этгээдийн тоо | - | Төлөвлөгөөний биелэлт, танилцуулга, цаашид авах арга хэмжээ, арга хэмжээний үр дүнг гаргасан байна. | Орон нутгийн өмчит байгууллагуудын хөрөнгийн бүртгэлийг Төрийн өмчийн тооллогын системд оруулж хөрөнгийг бүртгэлийг тулган баталгаажуулж, дансны бичилт, алдаатай бүртгэсэн код зэргийг засварлан хянаж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт нэгтгэлийг өгсөн.<br>Төрийн өмчийн тооллогын мэдээллийн системд Орон нутаг хөгжүүлэх сан-10, ОНӨХК-2, ОНӨААТҮГ-5, ӨЭМТ-8, төсөвт байгууллага-84 байна.<br>Орон нутгийн өмчит байгууллагуудын нийт хөрөнгө, хөрөнгийн ангиллаар дараах байдалтай байна.<br>Газар 33,554,352,600.00 төгрөг, Барилга, байгууламж 172,755,453,513.42 төгрөг, Нийтийн эзэмшлийн байгууламж 65,300,875,341.82 төгрөг, Машин, тоног төхөөрөмж 69,433,958,925.73 төгрөг, Тээврийн хэрэгсэл 17,294,556,126.76 төгрөг, Тавилга, эд хогшил 13,523,718,504.71 төгрөг, Худаг, усалтын систем 1,994,157,914.00 төгрөг, Дуусаагүй барилга 30,125,670,075.00 төгрөг, Биет бус хөрөнгө 4,127,115,103.90 төгрөг, Түүх соёлын дурсгалт зүйлс 702,804,700.00 төгрөг байна.<br>Орон нутгийн өмчит 107 байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд системийн хяналт хийж, хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн 74 байгууллагын 2,5 тэрбум төгрөгийн хөрөнгийг данс хооронд шилжүүлэх захирамжийн төсөл боловсруулан ажиллаж байна.<br>Нийт байгууллагуудаас улсын бүртгэлийн гэрчилгээнд байгууллагын нэр өөрчлөгдсөн 2, байгууллагын дарга, нягтлан бодогчийн мэдээлэл солигдсон 6 мэдээллийг төрийн өмчийн удирдлагын системд өөрчлөлтийг хийж ажиллалаа. | 100<br>100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.4 | Арга хэмжээ-4: Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгасан байдалд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх | Байгууллагын төсвөөр | Гүйцэтгэлийн шалгалтад хамрагдах хуулийн этгээдийн тоо | | Төлөвлөгөөний биелэлт, танилцуулга, цаашид авах арга хэмжээ, арга хэмжээний үр дүнг гаргасан байна. | Орон нутгийн өмчийн 12 барилга байгууламжид 12 иргэн, 12 аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллага ашиглалтын гэрээгээр үйл ажиллагаа явуулж байна. Мөн 8,8 сая төгрөгийн 14 ширхэг тоног төхөөрөмж, 2.340,4 сая төгрөгийн 21 тээврийн хэрэгслийг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа ба ашиглалтын байдалд хяналт, шалгалтыг явуулж, гарсан зөрчлийн талаар хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан. | 100 |
| 1.1.5 | Арга хэмжээ-5: Хяналт шалгалтын бүртгэлийн нэгдсэн санг бий болгох, бүртгэл мэдээллийн баяжилт хийх | Байгууллагын төсвөөр | Хяналт шалгалтын бүртгэл мэдээллийн иж бүрдлийн хувь | - | Төлөвлөгөөний биелэлт, танилцуулга, цаашид авах арга хэмжээ, арга хэмжээний үр дүнг гаргасан байна. | Орон нутгийн өмчит байгууллагуудаас 40 байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ, гэрээ, кадастрын зураг, 46 байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, 12 байгууллагын тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбарыг авч, бичиг баримтын зөрчлийг арилгуулан мэдээллийн сан бий болгон ажиллаж байна. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго-1.2: ӨМЧИЙН УДИРДЛАГА, ХЯНАЛТ**<br>**Орон нутгийн өмчит байгууллагуудын өмчийн удирдлагыг оновчтой, үр ашигтай, бүтээмжтэй байх зарчимд тулгуурласан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах** | | | | | | | |
| 1.2.1 | ЗОРИЛТ-2: Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, нэгтгэх, хувьчлах асуудлыг судлан дүгнэлт, санал боловсруулах | | | | | | |
| 2.1.1 | Арга хэмжээ-1: Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах, тайлагнах | Байгууллагын төсвөөр | Ажлын төлөвлөгөө гарган батлуулсан байна. | - | Төлөвлөгөөний биелэлт, танилцуулга, цаашид авах арга хэмжээ, арга хэмжээний үр дүнг гаргасан байна. | Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмчийн нэгдсэн бодлого, удирдлага, бүртгэл, мэдээллийн тогтолцоог сайжруулах чиглэлээр дагаж мөрдөх 6 журмын төслийг боловсруулахаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай, удирдах албан тушаалтнуудын албан тушаалын тодорхойлолт боловсруулахаар Удирдлагын академитай хамтран ажиллах гэрээ болон ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллалаа. | 100 |
| 2.1.2 | Арга хэмжээ-2: Хувьчлах орон нутгийн өмчийн эд | Байгууллагын төсвөөр | Төслийн тоо | - | Хувьчлах хөрөнгийн танилцуулга, | Орон нутгийн өмчөөс хувьчлах хөрөнгийн жагсаалтыг 2023 оны 11 дүгээр сард гаргаж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөрөнгийн жагсаалтыг боловсруулах, орон нутгийн өмчийн орон сууц хувьчлах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах, зохион байгуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллах, орон сууц хувьчлах товчооны ажиллах журмын хэрэгжилт, товчооны үйл ажиллагаанд хяналт тавих | | | | мэдээллийн төслийг бэлтгэж ажилласан байна. Ажлын тайланг гарган танилцуулсан байна. | хүргүүлсэн. Орон сууц хувьчлах товчооны ажиллах журмын дагуу орон сууц хувьчлах товчооны бүрэлдэхүүн 1 удаа хуралдах 00 өрөө хувьчлан авах хүсэлт гаргасан 3 иргэний хүсэлтийг судлан шийдвэрлэсэн. | |
| 2.2 | ЗОРИЛТ-3: Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, зорилтот түвшний талаар судалгаа, дүн шинжилгээ хийх | | | | | | |
| 2.2.1 | Арга хэмжээ-1: Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг хангуулах, судалгаа, шинжилгээ хийх, санал, дүгнэлт гаргах, үр ашгийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах | Байгууллагын төсвөөр | Төлөвлөгөө боловсруулсан байх | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнасан байна. | "Эрдэнэт Ус, дулаан түгээх сүлжээ" ОНӨХК, "Жаргалант Ус, дулаан түгээх станц" ОНӨХК "Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн парк" ОНӨААТҮГ, "Хот байгуулалт, барилга захиалагчийн алба" ОНӨААТҮГ, "Гэр бүлийн ордон" ОНӨААТҮГ, "Их шүтээн цогцолбор" ОНӨААТҮГ, Мэдээлэл шуурхай удирдлагын төв, Нийтлэг үйлчилгээний алба, Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар, Хот тохижуулах газар, "Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн" АӨЗ-ны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлийг 2023 оны байдлаар гарган Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн. 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг "Эрдэнэт Ус, дулаан түгээх сүлжээ" ОНӨХК 17 арга хэмжээ, "Жаргалант Ус, дулаан түгээх станц" ОНӨХК 17 арга хэмжээ, | 100. 100 |

47

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн парк" ОНӨААТҮГ 17 арга хэмжээ,<br>"Хот байгуулалт, барилга захиалагчийн алба" ОНӨААТҮГ 16 арга хэмжээ,<br>Мэдээлэл шуурхай удирдлагын төв 17 арга хэмжээ,<br>Нийтлэг үйлчилгээний алба 17 арга хэмжээ,<br>Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар 17 арга хэмжээ,<br>Хот тохижуулах газар 17 арга хэмжээ,<br>"Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн" АӨЗ 17 арга хэмжээний хүрээнд боловсруулан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний хавсралт болгон ажилласан.<br>"Гэр бүлийн ордон" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны орлого нь тогтвортой бус, орлогоороо өөрийгөө бүрэн санхүүжүүлэх чадваргүй. 2020-2023 онуудад 45,2-89,5 сая төгрөгийн өр төлбөртэй, 17,2-23,6 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж байгаа тул цаашид компанийн хэлбэрт шилжүүлэх, "Их шүтээн цогцолбор" ОНӨААТҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны жилийн орлого нь 1.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 2020-2023 онуудад 49,9-68,9 сая төгрөгийн зардлын санхүүжилт авсан, 88,9-168,6 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж байгаа зэрэг нь тус байгууллагыг татан буулгах талаар тодорхой ажлуудыг зохион байгуулан ажиллалаа. | |
| 2.3 | ЗОРИЛТ-4: Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, зорилтот түвшний талаар судалгаа, дүн шинжилгээ хийх | | | | | | |
| 2.3.1 | Арга хэмжээ-1:<br>Орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, удирдамж, чиглэл өгөх, хэрэгжилтийг | Байгууллагын төсвөөр | Тайлан, биелэлтийн тоо | - | Орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлсэн ажлын тайлан, удирдамжийн биелэлтийг | Орхон аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/90 дугаар захирамжаар Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийх, шалган зааварчлах, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг Мэдээлэл | 100.<br>100 |

48

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тооцох, танилцуулах, мэдээлэх, | | | | гаргасан байна. | шуурхай удирдлагын төв УТҮГ, Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн ашиглалтын өмнөх захиргаа, Их шүтээн цогцолбор ОНӨААТҮГ, Гэр бүлийн ордон ОНӨААТҮГ, Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламж УТҮГ, Хот тохижуулах газар УТҮГ, Нийтлэг үйлчилгээний алба УТҮГ, Жаргалант ус, ДТС ОНӨХК, Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ, Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ зэрэг байгууллагуудын үйл ажиллагаатай 2024 оны 04 дүгээр сарын 05, 07, 09, 10-ны өдрүүдэд танилцаж, Засгийн газрын тогтоол, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, ил тод байдлын хэрэгжилт, төрийн байгууллагуудад хэрэгжүүлж буй и-оффис систем ашиглалтын байдал, аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, Хөдөлмөрийн гэрээ, Контрактад тусгагдсан үзүүлэлтийн үнэлгээ, Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилттэй танилцаж зөвлөмж өгч, шалган зааварчлах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх Ажлын хэсгийн тайлан, дүгнэлт, зөвлөмжийг аймгийн Засаг дарга М.Түмэнжаргалд танилцуулан ажилласан. | |
| 2.3.2 | Арга хэмжээ-2: Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг нэгдсэн удирдлагаар | Байгууллагын төсвөөр | Зохион байгуулсан ажлын тоо | - | Нэгдсэн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах, үр дүнгийн тайлан | Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлагуудад зориулсан Компанийн засаглалын сургалтыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлага, төлөөллийн албаны дарга В.Дарханбаатар, мэргэжилтэн А.Молор, | 100. 100 |

49

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хангах ажлыг зохион байгуулах, үр дүнг тооцох | | | | | Б.Амарбаясгалан, Г.Нямдаваа нар 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад орон нутгийн өмчит “Эрдэнэт Ус, дулаан түгээх сүлжээ” ОНӨХК 7, “Жаргалант Ус, дулаан түгээх станц” ОНӨХК 4, “Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн парк” ОНӨААТҮГ 3, “Хот байгуулалт, барилга захиалагчийн алба” ОНӨААТҮГ 2, “Гэр бүлийн ордон” ОНӨААТҮГ 4, “Их шүтээн цогцолбор” ОНӨААТҮГ 3, Мэдээлэл шуурхай удирдлагын төв 3, Нийтлэг үйлчилгээний алба 3, Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар 2, Хот тохижуулах газар 2, "Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн" АӨЗ-ны 2, нийт 42, үүнээс төлөөлөн удирдах зөвлөлийн 15 гишүүн хамрагдсан байна.<br>Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компани хамтран 2024 оны 11 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд төрийн болон орон нутгийн өмчит компани, орон нутгийн өмчийн газрын мэргэжилтнүүдэд “Төрийн болон орон нутгийн өмчит компанийн шинэчлэл ба хөрөнгийн зах зээл” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК, “Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ” ОНӨХК-ийн захирал, ерөнхий нягтлан бодогч, эдийн засагчид хамрагдлаа. | |
| 2.3.3 | Арга хэмжээ-3:<br>Орон нутгийн өмчит газрын гүйцэтгэх захиралтай, гэрээ байгуулах, гэрээг дүгнэх, хэрэгжилтэд хяналт тавих | Байгууллагын төсөөр | Хөдөлмөрийн гэрээ байгуулсан байна. | - | Хөдөлмөрийн гэрээнд явцын хяналт тавих, гүйцэтгэлийн тайланг нэгтгэн дүгнэсэн байх | Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/90 дугаар захирамжаар Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, Орон нутгийн өмчийн хувьцаат компани, Улсын төсвийн үйлдвэрийн газруудын ажлын зорилт, үйл ажиллагааны хүрсэн үр дүнг үнэлж дүгнэн | 90.<br>100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -тайлагнах,-менежментийг-сайжруулах,-дүрэм-журам боловсруулж танилцуулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.<br>Ажлын хэсэг 2024 оны 02 дугаар сарын 20, 21-ны өдрүүдэд 2023 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцүүлсэн.<br>Ажлын хэсгийн хурлаар:<br>-Их шүтээн цогцолбор ОНӨААТҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны тайланг "хангалтгүй" гэж дүгнэж, татан буулгах санал боловсруулах, менежментийн хувьчлал хийх, Төлөөлөн удирдах зөвлөлийг шинэчлэх саналыг гаргасан.<br>-Эрдэнэт Ус, ДТС ОНӨХК-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланг "хангалттай",<br>-Гэр бүлийн ордон ОНӨААТҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны тайланг "хангалтгүй" гэж дүгнэн, орлого нэмэгдүүлэхэд анхаарах, Төлөөлөн удирдах зөвлөлийг шинэчлэх, засварын ажлын зураг төсвийг боловсруулах саналыг гаргаж,<br>-Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны тайланг "хангалттай",<br>-Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар УТҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны тайланг "хангалттай",<br>-Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны тайланг "хангалттай",<br>-Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн ашиглалтын өмнөх захиргааны 2023 оны үйл ажиллагааны тайланг "хангалттай",<br>-Хот тохижуулах газар УТҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны тайланг "хангалттай",<br>-Жаргалант Ус, ДТС ОНӨХК-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланг "хангалттай",<br>-Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн парк ОНӨААТҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тайланг “хангалттай” гэж дүгнэн, цаашид анхаарах асуудлыг хэлэлцсэн.<br>Аймгийн Засаг дарга М.Түмэнжаргал орон нутгийн өмчит 9 хуулийн этгээдийн дарга, захирал нартай “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-г 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр байгуулан, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Орон нутгийн өмчит 11 байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдөр авч нэгтгэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албанд хүргүүлсэн. | |
| 2.3.4 | Арга хэмжээ-4:<br>Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компанид засаглалын үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэх, хамтран ажиллах | Байгууллагын төсөөр | Засаглалын үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэсэн байна. | - | Компанид засаглалын үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан гаргасан байна. | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, төрийн болон орон нутгийн өмчийн компанийн тухай хууль батлагдсаны дараа орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн дүрэм, статусыг өөрчлөх, журмуудыг шинэчлэн батлах ажлууд хийгдэнэ. Үүний дараа орон нутгийн өмчит “Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ” ОНӨХК, “Жаргалант ус, дулаан түгээх станц” ОНӨХК-д засаглалын үнэлгээ хийлгэх ажлыг төрийн бус байгууллагаар хийлгэхээр төлөвлөн ажиллаж байна. | 30.<br>70 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго-3: ӨМЧИЙН АШИГЛАЛТ, ЗОХИЦУУЛАЛТ, БҮРТГЭЛ МЭДЭЭЛЭЛ**<br>**Орон нутгийн өмчийг үр ашигтай, үр дүнтэй, бүтээмжтэй байх зарчимд тулгуурласан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах** | | | | | | | |
| 3.1 | ЗОРИЛТ-1: Орон нутгийн өмчийн бүртгэл, эзэмшилт, ашиглалт, зохицуулалтын асуудлаар хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, шийдвэрийн санал, төсөл боловсруулах, шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг хангуулах, тайлагнах | | | | | | —5. |
| 3.1.1 | Арга хэмжээ-1:<br>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлого, чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөний | Байгууллагын төсөөр | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн дагуу төсөл боловсруулан, нэгтгэн танилцуулсан байна. | - | Орон нутгийн өмчийн бодлогын баримт бичгүүдийг шинэчлэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх | Орон нутгийн төсөвт байгууллагуудын нярав, нягтлан бодогч нарт "Төрийн өмчийн тооллогын систем"-д хөрөнгийн тайлан, мэдээг хэрхэн оруулах талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх сургалтыг 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулж, сургалтад 75 нягтлан бодогч, нярав хамрагдсан.<br>Төрийн өмчийн тооллогын нэгдсэн | 100.<br>100 |

12

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг хангах, эрх бүхий албан тушаалтныг мэргэжлийн зөвлөгөө, цаг үеийн мэдээллээр хангах, гаргах шийдвэр, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжийг сурталчлан таниулах, өмчийн харилцааны асуудлаар орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан хаагчид болон санхүү, бүртгэлийн ажилтнуудыг мэргэжил, арга зүйгээр хангах | | | | | системээс орон нутгийн өмчит 99 байгууллагад улс орон нутгийн төсөв, хандив, зээл тусламж, өөрийн орлогоос худалдан авсан 109,7. тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийг хийж, хянан ажилласан.<br>Орон нутгийн өмчийн бүртгэлийн асуудлаарх хууль тогтоомж, дүрэм, журмын талаар тухай бүр зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хамтран 2024 оны 08 дугаар сарын 14, 15-ний өдрүүдэд Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний хэрэгжилтийг дүгнэх, хөрөнгийн бүртгэл, мэдээллийн талаар сургалт зохион байгуулсан. Уг сургалтад төрийн өмчит 28 байгууллагын 54 албан хаагч оролцсон. | |
| 3.1.2 | Арга хэмжээ-2: Холбогдох хууль, тогтоомж, Улсын Их Хурал, Засгийн газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон бусад эрх бүхий байгууллагын шийдвэр, бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, журам, дүрмийн зүйл, заалт, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах, мэдээлэх | Байгууллагын төсөөр | Эрх бүхий байгууллагын шийдвэр, бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, журам, дүрмийн зүйл, заалт, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнасан байна. | - | Эрх бүхий байгууллагын шийдвэр, бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, журам, дүрмийн зүйл, заалт, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнасан байна. | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 47 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам", 48 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах журам, гэрээний загвар батлах тухай", 49 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж данснаас хасах журам" батлах тухай журмуудын дагуу хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчлэлтэй холбогдуулан "Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам"; | 50<br>70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам"; "Орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам"; "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам"; "Орон нутгийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цагийн цалин хөлсний хэмжээг тогтоох оролцоонд суурилсан холимог аргачлал" журмын төслүүдийг боловсруулж, батлуулах ажлын бэлтгэл ханган ажилласан. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, төрийн болон орон нутгийн өмчийн компанийн тухай хууль эцэслэн батлагдсаны дараа дээрх журмуудыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулна. | |
| 3.1.3 | Арга хэмжээ-3: Төрийн өмчөөс орон нутгийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх асуудлыг тухай бүр судлан шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг хангах, тайлагнах | Байгууллагын төсвөөр | Шийдвэр гарч, хэрэгжсэн байна. | - | Төрийн өмчөөс Орон нутгийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх асуудлыг тухай бүр судлан шийдвэрлүүлсэн байна. | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 100 дугаар тогтоолоор "Тогтвортой амьжиргаа-3" төслийн нэгжид ашиглагдаж байгаа 10 нэр төрлийн 10 ширхэг 8,304,833.81 төгрөгийн, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 49,436,333,365 төгрөгийн хөрөнгийг төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэн авсан. Тогтоолын дагуу хөрөнгийг Орон нутгийн өмчийн газар, "Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ" ОНӨХК-ийн санхүүгийн тайланд бүртгэн авч ашиглагч байгууллагын эд хөрөнгийн ашиглалтын гэрээгээр эзэмшүүлэн ажиллаж байна. | 100. 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2 | ЗОРИЛТ-2: Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, зохицуулалт, хадгалалт, хамгаалалтын асуудлыг судлан нэгтгэх, судалгаа, дүн шинжилгээ хийх, санал, төсөл боловсруулах, шийдвэрлүүлэх, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, тайлагнах" зорилтын хүрээнд | | | | | | |
| 3.2.1 | Арга хэмжээ-1: Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг төрийн өмчид шилжүүлэх асуудлыг судлах, хууль тогтоомжид нийцүүлэн баримт бүрдүүлэх, санал боловсруулах, танилцуулах, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, тайлагнах | Байгууллагын төсвөөр | Эрх бүхий этгээдийн шийдвэр гарч, хэрэгжсэн байна. | - | Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг төрийн өмчид шилжүүлэх асуудлыг тухай бүр судлан санал боловсруулж, танилцуулсан байх | Статистикийн хэлтсийн санхүүгийн тайланд бүртгэлтэй 184,525,853 төгрөгийн хөрөнгийг орон нутгийн өмчөөс шилжүүлэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас ирүүлсэн. Холбогдох хууль, журмын дагуу судлан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд танилцуулах саналыг бэлтгэсэн.<br>Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бий болсон 11.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг Төрийн өмчит байгууллагуудын хөрөнгөд бүртгэн авах тухай 11 удаагийн саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт албан тоотоор хүргүүлэн ажилласан байна. | 100<br>100 |
| 3.2.2 | Арга хэмжээ-2: Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зорилгоор хэрэгцээ, шаардлагатай байгууллагад балансаас балансад шилжүүлэх асуудлыг судлах, танилцуулах, шийдвэрлүүлэх, хөрөнгийн хөдөлгөөнийг бүртгэх ажлыг зохион байгуулах, хянах | Байгууллагын төсвөөр | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангасан байна. | - | Хөрөнгө шилжүүлэх санал ирүүлсэн тухай бүр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал болон аймгийн Засаг даргын шийдвэрээр шилжүүлсэн байна. | Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/134 дүгээр захирамжаар орон нутгийн өмчит 4 байгууллагад ашиглагдаж байгаа нийт 4,104,430,047 төгрөгийн, 152,597,843.28 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 3,951,832,203.72 төгрөгийн үлдэх өртөгтэй 95 нэгж хөрөнгийг, 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/411 дүгээр захирамжаар орон нутгийн өмчит 8 байгууллагад ашиглагдаж байгаа нийт 2,320,623,151.47 төгрөгийн, 228,482,531.96 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 2,092,140,619.51 төгрөгийн үлдэх өртөгтэй 4793 нэгж хөрөнгийг, 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/463 дугаар захирамжаар орон нутгийн өмчит 1 байгууллагад ашиглагдаж байгаа нийт 9,990,000 төгрөгийн, 9,990,000 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, үлдэх өртөггүй 1 хөрөнгийг, 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/543 дугаар захирамжаар орон | 100<br>100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нутгийн өмчит 1 байгууллагад ашиглагдаж байгаа нийт 726,421,940 төгрөгийн, 726,421,940 төгрөгийн үлдэх өртөгтэй 27 нэгж хөрөнгийг, 2024 оны 07 дугаар сарын 26-ны А/543 дугаар захирамжаар орон нутгийн өмчит 2 байгууллагад ашиглагдаж байгаа нийт 726,421,940 төгрөгийн, 0 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 726,421,940 төгрөгийн үлдэх өртөгтэй 27 нэгж хөрөнгийг, 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/729 дүгээр захирамжаар орон нутгийн өмчит 1 байгууллагад ашиглагдаж байгаа нийт 565,334,300 төгрөгийн, 41,047,810,98 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 524,286,489 төгрөгийн үлдэх өртөгтэй 3 нэгж хөрөнгийг, 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/729 дүгээр захирамжаар орон нутгийн өмчит 1 байгууллагад ашиглагдаж байгаа нийт 565,334,300 төгрөгийн, 524,286,489 төгрөгийн үлдэх өртөгтэй 3 нэгж хөрөнгийг байгууллага хооронд балансаас балансад шилжүүлсэн. | |
| 3.2.3 | Арга хэмжээ-3: Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг дахин үнэлэх, үнэлгээг шинэчлэн тогтоох, ашиглалтын хугацааг сунгах, өөрчлөх асуудлаар ирүүлсэн санал, захиалгыг хянах, шийдвэрлүүлэх | Байгууллагын төсвөөр | Хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан байна. | - | Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг дахин үнэлэх, үнэлгээг шинэчлэн тогтоох, ашиглалтын хугацааг сунгах, өөрчлөх асуудлаар ирүүлсэн санал, захиалгыг тухай бүр хянан, шийдвэрлүүлэх | Орон нутгийн өмчит байгууллагуудын 2024 оны жилийн эцсийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллого хийгдэж байна. Орон нутгийн өмчийн газрын жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг 2024 оны 11 дүгээр сарын 04-11-ний өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Тооллогоор барилга байгууламжийн дансанд бүртгэлтэй 14.816,6 сая төгрөг, нийтийн эзэмшил дансанд бүртгэлтэй 1.303,6 сая төгрөг, тээврийн хэрэгсэл дансанд бүртгэлтэй 2.375,4 сая төгрөг, машин тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй 136,9 сая төгрөг, тавилга эд хогшлын дансанд бүртгэлтэй 122,5 сая төгрөг, биет бус хөрөнгө дансанд бүртгэлтэй 1.330,0 сая | 100. 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөг, нийт 103.619,9 сая хөрөнгийн хөрөнгө тоологдсон. Дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй 83.618,5 сая төгрөгийн 78 ажлыг Хот байгуулалт, барилга захиалагчийн албаны бүртгэлтэй 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар тулган үзэхэд тайлант онд 100 хувийн гүйцэтгэлтэй 15 ажлыг хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна. Эргэлтийн хөрөнгийн 6 дансанд бүртгэлтэй 6,8 сая төгрөгийн бараа материалыг тооллогод хамруулсан. Тооллогын үр дүнгээр элэгдлээрээ өртгөө нөхөж, тайлант хугацааны эцэст 0,00 үлдэгдэлтэй болж байгаа, цаашид ашиглагдах 6 дансны 17 ширхэг хөрөнгийн үнэ шинэчлэн тогтоох хүсэлтийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлд хүргүүлсэн. | |
| 3.2.4 | Арга хэмжээ-4: Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг худалдах, шилжүүлэх, актлах санал, захиалгыг судлах, хянаж шийдвэрлүүлэх, хөрөнгийн хөдөлгөөнийг бүртгэх | Байгууллагын төсвөөр | Үйл ажиллагаа хуульд нийцсэн байна. | - | Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг худалдах, шилжүүлэх, актлах санал, захиалгыг судлах, хянаж шийдвэрлүүлэх, хөрөнгийн хөдөлгөөнийг бүртгэсэн байна. | Орон нутгийн өмчит 15 байгууллагад ашиглагдаж байсан цаашид сэлбэн ашиглахад эдийн засгийн үр өгөөжгүй нь тогтоогдсон нийт 605,337,164.09 төгрөгийн, 535,040,484.24 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 70,296,679.85 төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийг аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/543 дугаар захирамжаар акталсан, 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар 17 байгууллагаас актлуулах санал ирүүлсэн нийт 775,009,669.35 төгрөгийн балансын үнийн дүнтэй, 755,796,947.98 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 19,214,521.43 төгрөгийн үлдэх өртөгтэй 1952 нэгж хөрөнгийг актлуулах саналыг судлан "Хөрөнгө актлах тухай" аймгийн Засаг даргын захирамжийн төслийг боловсруулан и-оффис системд санал авч байна. Мөн аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/542 дугаар | 90. 90 |

57

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | захирамжаар орон нутгийн өмчит 1 байгууллагад ашиглагдаж байсан 44,400,000 төгрөгийн балансын өртөгтэй, 43,150,000.23 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 1,249,999.77 төгрөгийн үлдэх өртөгтэй 2 тээврийн хэрэгслийг акталж, сэлбэг материалаар ашиглахаар шийдвэрлүүлсэн. | |
| 3.2.5 | Арга хэмжээ-5: Барилга байгууламж, эд хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг сайжруулах зорилгоор ашиглуулах, түрээслэх журам, заавтыг боловсруулах, танилцуулах, түрээсийн төлбөрийг зах зээлийн үнэд нийцүүлэн нутаг дэвсгэрээр бүсчлэн тогтоож, гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, түрээсийн төлбөрийг төсөвт төвлөрүүлэх | Байгууллагын төсөвөр | Орон нутгийн өмчит хуулийн этгээдээс ирүүлсэн санал хянагдаж, шийдвэрлэгдсэн байна. Түрээсийн орлогын төлөвлөгөө биелсэн байна. | - | Түрээсийн орлогын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны 13/05 дугаар тогтоолоор орон нутгийн өмчийн байрны 2024 оны шууд түрээсийн орлогын төлөвлөгөөг 686.6 сая төгрөгөөр, дам түрээсийн орлогын төлөвлөгөөг 80,2 сая төгрөгөөр батлуулан мөрдөн ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу 16 төсвийн байгууллага, 1 төрийн бус байгууллага, 6 аж ахуй нэгжтэй шууд түрээсийн, 14 аж ахуй нэгжтэй дам түрээсийн гэрээг байгуулсан. 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар 569,2 сая төгрөгийн шууд түрээсийн орлого, дам түрээсийн 60,2 сая төгрөг, нийт 629,4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж шууд түрээсийн орлого 80 хувийн, дам түрээсийн орлого 75 хувийн биелэлттэй байна. 766,8 | 82,1<br>82.1 |
| 3.3 | ЗОРИЛТ-3 Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл хөтлөх, үзлэг, тооллого зохион байгуулах, тайлагнах зорилтын хүрээнд | | | | | | -7. |
| 3.3.1 | Арга хэмжээ-1: Орон нутгийн өмчийн (улсын) эд хөрөнгийн үзлэг, тооллогыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах, тооллогын дүнг нэгтгэх, цаашид авах арга хэмжээний | Байгууллагын төсөвөр | Журам, аргачлал, заавтын дагуу тооллого зохион байгуулагдсан байна. Тооллогын дүн улсын дүнд нэгтгэгдсэн байна. | - | Эд хөрөнгийн үзлэг, тооллогыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, тооллогын дүнг нэгтгэх, цаашид авах арга | Орон нутгийн өмчит 107 хуулийн этгээдийн 2023 оны эд хөрөнгийн үзлэг тооллогын 630,964,212,709 төгрөгийн дүнг Төрийн өмчийн тооллогын https://umch.sgov.mn/ системд цахимаар нэгтгэн улсын дүнд цаг хугацаанд нь нэгтгүүлсэн.<br>Төрийн өмчийн тооллогын мэдээллийн системд Орон нутаг хөгжүүлэх сан-10, ОНӨХК-2, ОНӨААТҮГ-4, ӨЭМТ-8, төсөвт | 100.<br>100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | -санал бэлтгэж-танилцуулах, тооллогын мөрөөр гарсан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах, мэдээлэх | | | | -хэмжээний санал-бэлтгэж танилцуулсан байх. | -байгууллага-83 байна. Орон нутгийн өмчит байгууллагуудын нийт хөрөнгө, хөрөнгийн ангиллаар дараах байдалтай байна. Газар 33,554,352,600.00 төгрөг, Барилга, байгууламж 172,755,453,513.42 төгрөг, Нийтийн эзэмшлийн байгууламж 65,300,875,341.82 төгрөг, Машин, тоног төхөөрөмж 69,433,958,925.73 төгрөг, Тээврийн хэрэгсэл 17,294,556,126.76 төгрөг, Тавилга, эд хогшил 13,523,718,504.71 төгрөг, Худаг, услалтын систем 1,994,157,914.00 төгрөг, Дуусаагүй барилга 30,125,670,075.00 төгрөг, Биет бус хөрөнгө 4,127,115,103.90 төгрөг, Түүх соёлын дурсгалт зүйлс 702,804,700.00 төгрөг байна. Хөрөнгийн ангилал, нэр төрөл, марк зөрүүтэй хөрөнгийн алдааг залруулах ажлыг төрийн өмчийн тооллогын нэгдсэн системд бүртгэсэн. | |
| 3.4 | ЗОРИЛТ-4: Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн болон хөрөнгийн мэдээ, тайланг хүлээн авч, мэдээллийн санг баяжуулах ажлыг зохион байгуулах, мэдээлэл нэгтгэх, дүгнэлт, мэдээлэл, тайлан гаргах" зорилтын хүрээнд | | | | | | 8 |
| 3.4.1 | Арга хэмжээ-1: Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн жилийн эцсийн санхүүгийн тайланг цахимаар болон цаасаар хүлээн авч нэгтгэх, санхүүгийн тайланг Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон аймгийн Засаг даргын нэгдсэн санхүүгийн тайлантай тулган, хяналт тавих | Байгууллагын төсвөөр | Хууль тогтоомж хэрэгжсэн байна. | - | Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн жилийн эцсийн санхүүгийн тайланг хүлээн авч (цахимаар) нэгтгэсэн байна. | Орон нутгийн өмчит 107 хуулийн этгээдийн 630,964,212,709 төгрөгийн хөрөнгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон аймгийн Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайлан, Сангийн яамны и-бланстай нэгтгэн тулган баталгаажуулж 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт нэгтгүүлэн ажилласан. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний 109.7 тэрбум төгрөгийн хөрөнгийг 2024 оны санхүүгийн тайланд тусгуулах орон нутгийн өмчийн нэгдсэн бүртгэлд авах ажилд хяналт тавин ажиллалаа. | 100. 100 |
| 3.4.2 | Арга хэмжээ-2: | Байгууллагын | Статистикийн | - | Статистикийн | Орон нутгийн өмчит 107 хуулийн этгээдийн | 100 – 100. |

59

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Үндэсний статистикийн хороонд өмчийн бүртгэлийн болон захиргааны статистикийн дүн мэдээг хүргүүлэх, орон нутгийн өмчийн нэгдсэн дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах ажлыг зохион байгуулах | төсвөөр | мэдээг хугацаанд нь хүргүүлсэн байна. | | мэдээг хугацаанд нь хүргүүлсэн байх | 630,964,212,709 төгрөгийн хөрөнгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон аймгийн Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайлан, Үндэсний статистикийн хорооны нэгтгэл, Сангийн яамны и-бланстай нэгтгэн тулган баталгаажуулж 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт нэгтгүүлэн ажилласан.<br>Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 17/04 дүгээр тогтоолоор орон нутгийн өмчийн 2023 оны дүнг батлуулсан. | |
| 3.5 | ЗОРИЛТ-5: Орон нутгийн өмчийн мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалд бүртгэлээр системийн хяналт хийх, дүгнэлт гаргах, зөвлөмж мэдээлэл, зөвлөгөө өгөх, мэргэжил, арга зүйгээр хангаж, дэмжлэг үзүүлэх | | | | | | – 9. |
| 3.5.1 | Арга хэмжээ-1:<br>Орон нутгийн өмчийн бүртгэлийн мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалд бүртгэлээр системийн хяналт хийх, дүгнэлт гаргах | Байгууллагын төсвөөр | Мэдээллийн санг бүрдүүлж, баяжуулсан байна. | - | Бүртгэлийн мэдээллийн санг тухай бүр бүрдүүлж, баяжуулсан байна. | Орон нутгийн өмчийн мэдээллийн санг бүрдүүлэн, хөрөнгө тус бүрийн мэдээллийг цахим системд оруулан хяналт тавьж байна. Орон нутгийн өмчийн бүртгэл хөтлөлт, үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийг тухай бүр бүртгүүлэн өмчийн тооллогын ТӨ, ТӨХ маягт, орлогын баримт албан тоотоор баталгаажуулан ажилласан.<br>Нийт 289 ажлын улсын комисст, 150 бараа хүлээн авах комисст ажиллаж, шинээр бий болсон хөрөнгийг бүртгэлжүүлж, гүйцэтгэлийн баримт, хөрөнгийн мэдээллээр цахим сан үүсгэн ажилласан. | 100<br>100 |
| 3.5.2 | Арга хэмжээ-2:<br>Орон нутгийн өмчит хуулийн этгээдтэй өмч эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх ажлыг зохион байгуулах, орон нутгийн өмчийн бүрэн | Байгууллагын төсвөөр | Орон нутгийн өмчит хуулийн этгээдтэй өмч эзэмшүүлэх гэрээ байгуулсан байна. | - | Орон нутгийн өмчит хуулийн этгээдтэй өмч эзэмшүүлэх гэрээний тайланг бэлтгэсэн байна. | Орон нутгийн өмчит хуулийн этгээдтэй өмч эзэмшүүлэх гэрээ байгуулах журмын төсөл, өмч эзэмшлийн гэрээний загвар, гэрээг дүгнэх аргачлалыг боловсруулсан.<br>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, төрийн болон орон нутгийн өмчийн компанийн тухай хууль эцэслэн батлагдсаны дараа | 100.<br>100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүтэн байдалд бүртгэлээр системийн хяналт тавих, дүнг нэгтгэн тайлагнах | | | | | дээрх журмуудыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахад бэлэн болсон.<br>Улсын төсвийн 2,4 тэрбум төгрөгийн 1 ажил, орон нутгийн төсвийн 80,9 тэрбум төгрөгийн 174 ажил, Баян-Өндөр сумын орон нутгийн хөгжлийн сангийн 8,9 тэрбум төгрөгийн 89 ажил, Жаргалант сумын орон нутгийн хөгжлийн 7,6 тэрбум төгрөгийн 25 ажил, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 13,8 тэрбум төгрөгийн 83 бараа, Баян-Өндөр сумын хөрөнгө оруулалтаар 3,2 тэрбум төгрөгийн 33 бараа, Жаргалант сумын хөрөнгө оруулалтаар 1,8 тэрбум төгрөгийн 34 барааг гэрээний дагуу орон нутгийн өмчит байгууллагуудад хүлээлгэн өгч санхүүгийн тайланд бүртгэлд авахуулж ажиллалаа. | |
| **ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| | ЗОРИЛТ-2.1: Бодлогын баримт бичгийн холбогдох заалтуудын биелэлтийг хангаж ажиллах | | | | | | -10. |
| 2.1.1 | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөөний 1 зорилтын 2 арга хэмжээний хэрэгжилтийг хангаж биелэлтийг цаг хугацаанд гаргаж хүргүүлэх | | Холбогдох заалт бүрийг хэрэгжүүлж, тайланг хугацаанд нь гаргах | | Хагас жил: 50%<br>Бүтэн жил: 100% | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн арга хэмжээний 3.7.9 дүгээр зорилтын “Аймгуудын төвд түрээсийн орон сууц барих ажлыг хамтран зохион байгуулна” арга хэмжээний, 6.2.12 дугаар зорилтын “Аймгийн төвөөс алслагдсан сумдад ажиллаж, амьдарч байгаа эрүүл мэнд, боловсрол, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагын албан хаагчдын ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд албаны орон сууцаар хангах ажлыг зохион байгуулна” арга хэмжээний хэрэгжилтийг сар бүр гаргаж, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст и-оффис системээр хүргүүлэн ажилласан. | 100<br>100. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.2 | Тайлангийн хугацаанд иргэд олон нийтийг оролцуулах, нийтэд хамааралтай ажлыг байгууллагынхаа хэмжээнд болон бусад байгууллагатай хамтран үр дүнтэй хэлбэрээр зохион байгуулах | | Нийтийн хамруулан зохион байгуулах | | Хагас жил: 50%<br>Бүтэн жил: 100% | Орлогод нийцсэн орон сууцанд иргэдийг хамруулах ажлын хүрээнд "Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн парк" ОНӨААТҮГ-ын мэдээллийн технологийн ажилтантай хамтран смарт эрдэнэт апликейшнээр 2024 оны 04 дүгээр сарын 10, 11-ний өдрүүдэд "Орлогод нийцсэн орон сууц"-д орох иргэдийн бүртгэлийг цахимаар хийсэн.<br>Нийт 702 иргэн цахимаар бүртгүүлсэн. | 100<br>100 |
| 2.1.3 | Аймаг орон нутгаас батлан хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэр, дэд хөтөлбөрүүдийн албанд холбогдох заалтыг хэрэгжүүлж, олон нийтэд хүргэн сурталчлах | | Холбогдох заалт бүрийг хэрэгжүүлж сурталчлах, тайланг хугацаанд нь гаргах | | Хагас жил: 50%<br>Бүтэн жил: 100% | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн "Орон сууцны хөтөлбөр батлах тухай" 10/05 дугаар тогтоол, 2023 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Орлогод нийцсэн орон сууцны журам батлах тухай" 17/06 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Тогтоолыг Орхон аймгийн www.erdenem.mn, Орон нутгийн өмчийн газрын www.umch-erdenet.mn вэбсайтаар болон байгууллагын нээлттэй хаалганы өдрөөр олон нийтэд хүргэн сурталчлах, иргэдэд мэдээлэл өгч ажиллалаа. | 100<br>100 |
| 2.1.4 | Иргэдэд байгууллагын үйл ажиллагааны талаар сурталчилах зорилгоор нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах | | Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулах тоо | | Хагас жил: 1<br>Бүтэн жил: 1 | Байгууллагын нээлттэй хаалганы өдөрлөгийг 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр А.Амарын талбайд орон нутгийн өмчит 9 байгууллагатай хамтран зохион байгуулан ажиллалаа. Нээлттэй хаалганы өдрөөр 65 иргэнээс санал асуулга авсан. Санал асуулгаар байгууллага болон албан хаагчдад ирсэн гомдол байхгүй байлаа. | 100<br>100 |
| **ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 4 ХҮНИЙ НӨӨЦ<br>Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, уялдаа холбоог хангах, гүйцэтгэл, үр дүнд хяналт тавьж, хэрэгжилтийг хууль тогтоомжийн дагуу нэгтгэн тайлагнах** | | | | | | | |
| 3.1 | ЗОРИЛТ-3.1: Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, уялдаа холбоог хангах, гүйцэтгэл, үр дүнд хяналт тавьж, хэрэгжилтийг хууль тогтоомжийн дагуу нэгтгэн тайлагнах" | | | | | | |

11

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.1 | Арга хэмжээ-1: Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих | | Байгууллагын стратеги, холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг, бодлогын зорилттой уялдсан байна. | | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 90-ээс дээш хувьтай байна. | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилго, 21 зорилт, 75 арга хэмжээний хүрээнд боловсруулан батлуулсан бөгөөд гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт оны эцсээр 98.4 хувьтай байна. | 98.4 |
| 3.1.2 | Арга хэмжээ-2: Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг нэгтгэх, үр дүнг албан хаагчид, олон нийтэд мэдээлэх | | Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал хангагдсан байна. | | Байгууллагын үйл ажиллагааны тайланг мэдээлсэн байна. | Албан хаагчдаас гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр авч, нэгтгэн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг хагас, бүтэн жилээр www.umch-erdenet.mn вэбсайтад байршуулан ажиллалаа. | 100<br>90. |
| 3.1.3 | Арга хэмжээ-3: Байгууллагын үйл ажиллагаа, холбогдох бусад тайлан, мэдээллийн ил тод байдлыг хангах ажлыг зохион байгуулах, мэдээлэх | | Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал хангагдсан байна. | | Байгууллагын нийтэд нээлттэй мэдээллүүд нийтлэгдсэн байна. | www.umch-erdenet.mn сайтад байгууллагын Төсвийн ил тод байдлын-2,<br>Дотоод аудитын-1,<br>Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тайлан-3,<br>Орон нутгийн өмчит байгууллагуудын ил тод байдлын-2,<br>Сул орон тооны зарлал-5<br>Худалдан авах ажиллагааны ерөнхий тайлан-1,<br>Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө-1,<br>Гүйцэтгэгч шалгарсан, шалгараагүй мэдээлэл-1,<br>Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө-1,<br>Тендер шалгаруулалтын зарлал-39 буюу 56 удаагийн 9 төрлийн мэдээллийг нийтэлсэн.<br>Байгууллагын бүтэц, орон тоо өөрчлөгдсөнтэй холбоотойгоор вебсайтын мэдээллийг шинэчлэн ажиллалаа. | 100<br>90. |
| 3.2 | ЗОРИЛТ-3.2: Хууль тогтоомж, бодлого, шийдвэр, дотоод журам, дүрмийн санал, төсөл боловсруулах, хэрэгжилтийг нэгтгэх, тайлагнах” | | | | | | |

-12

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.1 | Арга хэмжээ-1: Байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөх журам, дүрэм, заавар, тушаал шийдвэрийн төсөл боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих | | Төрийн захиргааны байгууллагын нийтлэг чиг үүргийн хэрэгжилтийн зохицуулалт хангагдсан байна. | | Байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөх бодлогын баримт бичгүүдийг шинэчлэн батлуулсан байна. | Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам, Баримт нягтлан шалгах комиссын ажиллах журам, Албан хэрэг хөтлөлтийн журмыг шинээр боловсруулж батлан ажиллалаа.<br>Байгууллагын хэмжээнд хүний нөөцтэй холбоотой Б тушаал 18, бусад үйл ажиллагаатай холбоотой А тушаалын 54 төслийг боловсруулан, хуулийн мэргэжилтнээр хянуулан, баталж ажилласан. | 100<br>100. |
| 3.2.2 | Арга хэмжээ-2: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих | | Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна. | | Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээ зохион байгуулсан байна. | Томуу, томуу тест өвчний дэгдэлт ихтэй, хүйтний улиралд албан хаагчдын дархлааг дэмжих бүтээгдэхүүн олгоход зориулж 2,012,800 төгрөгийг байгууллагын төсвөөс зарцуулсан.<br>Албан хаагчдыг эрүүл чийрэг, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор спортоор хичээллүүлэх нөхцөл боломжоор хангах зорилгоор ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн спорт заалыг гэрээгээр ашиглан, албан хаагчдад гар бөмбөгийн анхан шатны сургалтыг Батсүх багшаар заалган хичээллэж байна.<br>Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар орон нутгийн эмнэлгийн байгууллагууд болох Баян-Өндөр мед эмнэлэг, Эрдэнэт медикал эмнэлэг, Улаанбаатар хотын Гранд мед эмнэлэг, Интермед эмнэлэг, Нура төв зэрэг эмнэлгийн байгууллагуудын багцын судалгааг хийж, үзлэг оношилгооны 9,830,000 төгрөгийн төсвийг байгууллагын зардлын төсөвт тусгуулан албан хаагчдыг "Баян-Өндөр мед" эмнэлэг болон "Туяа эхо" ХХК-нд үзлэг оношилгоонд хамрууллаа. | 100<br>100. |
| 3.2.3 | Арга хэмжээ-3: Байгуулллагын худалдан авах ажиллагааг төлөвлөх, | | Хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион | | Хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион | 2024 онд шууд худалдан авалтын 8 гэрээгээр 39,4 сая төгрөгийн тавилга эд хогшил, 36,5 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийн хөрөнгийг худалдан авч данс | 100<br>100. |

64

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих | | байгуулсан байна. | | байгуулсан байна. | бүртгэлд тусган ажиллалаа. | |
| 3.2.4 | Арга хэмжээ-4: Байгууллагаас зохион байгуулах олон нийтийн болон цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээг зохион байгуулах, хамтран ажиллах | | Албан хаагчдын тэгш оролцоог хангасан байна. | | Арга хэмжээ зохион байгуулсан байна. | 2024 оны 02 дугаар сард улсын хэмжээнд зохион байгуулан явуулсан "Малчдад туслах аян"-д нэгдэж, 8 шуудай хивэг, 12 кг төл малын хуурай сүү бэлтгэн хандивласан.<br>Аймгийн хэмжээнд хаврын бүх нийтээр мод тарих өдөр Тарлан толгойн энгэрт Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтнүүдийн зөвлөмжийн дагуу 11 ширхэг бүйлс мод тарьсан.<br>Аймгийн хэмжээнд бүх нийтийн цэвэрлэгээний дагуу Баян-Өндөр уулын урд энгэр, рашааны ойр орчмын хогийг цэвэрлэн Хот тохижуулах газрын хогийн машинд ачуулсан.<br>Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын нэрэмжит төрийн байгууллагуудын дундах Гар бөмбөгийн тэмцээнд байгууллагын албан хаагчид оролцож, эрэгтэй баг дэд байр эзэлсэн.<br>Эцэг эхийн зөвлөлөөс тайлант хугацаанд хэрэгжүүлэн ажиллах 9 заалт бүхий ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган тайланг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт хүргүүлсэн.<br>Байгууллагын "Ёс зүйн дэд зөвлөл"-ийг А/32 дугаар тушаалаар байгуулж, 2024 оны төлөвлөгөөг 11 арга хэмжээний хүрээнд төлөвлөн, биелэлтийг холбогдох байгууллагуудад хагас, бүтэн жилээр тайлагнан ажиллалаа. | 100<br>100. |
| 3.3 | ЗОРИЛТ-3.3: Хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгаа, сургалт, хөгжлийн асуудлаар хөтөлбөр, төлөвлөгөө, санал, төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг тайлагнах" | | | | | | —13 |
| 3.3.1 | Арга хэмжээ-1: Хүний нөөцийн асуудлаар холбогдох | | Санал нь үндэслэлтэй, хууль тогтоомжид | | Хүний нөөцийн асуудлаар холбогдох | Байгууллагын хүний нөөцийн асуудалтай холбоотой 44 судалгааг гарган Төрийн албаны зөвлөл болон бусад | 100<br>100. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | -судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, авах арга хэмжээ, шийдвэрийн санал, төсөл боловсруулах, танилцуулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх | | -нийцсэн байна. | | -судалгаа, шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлэсэн байна. | -байгууллагуудад хүргүүлсэн. Үүнд: Төрийн албаны зөвлөлд шинээр батлагдсан албан тушаалын тодорхойлолтууд, албан тушаалын чиг үүрэг, тусгай шаардлагын мэдээллүүд, албан хаагчдын томилгоо, ажилласан жилийн талаарх, бүтэц, орон тоо, сул орон тооны мэдээ, судалгааг гаргаж, хэрэгжилтийг ханган ажилласан. Албан хаагчдын зэрэг дэвийг ахиулах түүнд шаардлагатай төсөв, ажилласан жилийн болон бусад нэмэгдлийн судалгааг гаргаж 2025 оны төсөвт тусгуулах арга хэмжээг авч ажиллалаа. | |
| 3.3.2 | Арга хэмжээ-2: Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны ёс зүйн тухай хууль, тогтоомж, бодлого, үзэл баримтлалыг төрийн албан хаагчдад танилцуулах, сурталчилах, төрийн албан хаагчдын харилцаа, хандлагад анхаар ажиллах, нөлөөллийн арга хэмжээ авч хэрэгжүүлэн ажиллах | | Байгууллагын хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал хангагдсан байна. | | Хууль тогтоомж, дүрэм, журмыг сурталчлан таниулсан байна. | Байгууллагын бүтэц, орон тоо өөрчлөгдсөнтэй холбоотойгоор байгууллагын даргын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/28 дугаар тушаалаар Баримт нягтлан шалгах комиссыг шинэчлэх, 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/15 дугаар тушаалаар Эцэг эхийн зөвлөлийг байгуулах, 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/29 дүгээр тушаалаар Өмч хамгаалах байнгын зөвлөлийг шинэчлэх, 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/30 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хороодын гишүүдийг шинэчлэн баталсан. Ажлын хэсгүүд чиг үүргийн дагуу ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. Шинээр орсон албан хаагчдад хууль, тогтоомж, бодлого, үзэл баримтлалыг танилцуулж нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулан ажилласан. | 100 100. |
| 3.3.3 | Арга хэмжээ-3: Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах арга хэмжээг төлөвлөж, байгууллага, нэгжийн жилийн төлөвлөгөөнд | | Судалгаанд үндэслэсэн, хэрэгжих боломжтой байна. | | Төлөвлөгөөний дагуу арга хэмжээ зохион байгуулсан байна. | Байгууллагын даргын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/13 дугаар тушаалаар Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр, хөтөлбөртэй уялдуулан 2024 оны төлөвлөгөөг батлуулан ажилласан. Төлөвлөгөөний дагуу 5 албан хаагчийн | 100 100. |

66

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тусгуулж, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах | | | | | компьютерийг иж бүрэн сольж, 4 албан хаагчийн принтерийг шинэчилж, ажлын ачааллыг хөнгөвчилж хурдны скайнер 4 ширхгийг шинээр авсан.<br>Бүтэц орон тоо шинэчлэгдэж, шинээр албан хаагчид авсантай холбоотойгоор 4 албан хаагчийн ширээ, номын шүүгээг шинэчилсэн. Үе шаттайгаар албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах ажлыг хийж байна.<br>Байгууллагад ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан 2 албан хаагчид сар шинийн баяр, ахмадын баярыг тохиолдуулан тухай бүр хүндэтгэл үзүүлсэн.<br>Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын дагуу 2024 оны А/20 дугаар тушаалаар албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн баталсан.<br>Мөн Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолын дагуу Төрийн захиргааны албанд 5 жил тасралтгүй ажилласан 4 албан хаагчид 12 сарын үндсэн цалингийн дунджийг 6 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний 25,5 сая төгрөгийн мөнгөн урамшууллыг журмын дагуу олгосон.<br>Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан албан хаагчдын хүүхдүүдийн дархлаа дэмжих үйл ажиллагааг хагас, бүтэн жилээр зохион байгуулсан.<br>Байгууллагад тогтвор суурьшилтай ажиллаж байгаа албан хаагчийн 50 насны ойн баярыг тохиолдуулан үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулсан.<br>Байгууллагын дотоод журамд заасны дагуу 3 удаагийн буцалтгүй тусламжийг 2 албан хаагчид үзүүлж ажиллалаа. | |

67

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.4 | Арга хэмжээ-4: Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг хангах, төрийн албан хаагчийг сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах | | Сургалтын хэрэгцээг тодорхойлсон судалгааг үндэслэсэн, хэрэгжих боломжтой байна. | | Төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг хангасан байна. | Байгууллагын даргын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/13 дугаар тушаалаар Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны 2024 оны хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулан мөрдөн ажилласан.<br>Сургалтын төлөвлөгөөний дагуу Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийн чиглүүлэх богино хугацааны сургалтад 4 албан хаагч, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 албан хаагч, албан хэрэг хөтлөлтийн сургалтад Архив, бичиг хэргийн эрхлэгч, Хойд бүсийн хөгжлийн форум болон Цахим хөгжлийн яамны сайдын тушаалын дагуу "Цахимд хэвшье-Digital first" сургалт, өдөрлөгт нийт албан хаагчид, Эдийн засаг хөгжлийн яам, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран зохион байгуулсан "Бодлогын баримт бичгийг үр дүнд суурилсан арга зүйгээр боловсруулах нь" 2 өдрийн сургалтад 2 албан хаагч, Сэтгэл зүйч Г.Наранбаатарын "Хамгийн чухал нь гэр бүл" сургалтад 3 албан хаагч, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас зохион байгуулж байгаа бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх, Кибер аюулгүй байдлын "Цахимд зөв байя" сургалтад 5 албан хаагч, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг уялдуулан төлөвлөх, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх арга зүйн мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх зорилгоор "Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл" сэдэвт 2 өдрийн сургалтад 1 албан хаагч, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ | 100<br>100. |

68

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мониторинг хийх арга хэлбэрийг өөрчлөх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, үр дүнд суурилсан үнэлгээ мониторингийн тогтолцоог хөгжүүлэхээр шинэчлэн найруулсан журмын төслийг танилцуулж, санал авах сургалт, хэлэлцүүлэгт 2 албан хаагч, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан Цахимаар залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалтад байгууллагын 1 албан хаагч, Тагнуулын ерөнхий газрын Орхон аймаг дахь газраас зохион байгуулсан нууцын ажилтны сургалтад 1 албан хаагч, Жендерийн эрх тэгш байдлыг хангах зорилгоор Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалтад 2 албан хаагч хамрагдсан.<br>Давхардсан тоогоор 2024 онд 31 удаагийн сургалтад 40 албан хаагч хамрагдаж, сургалтын талаарх мэдээллийг албан хаагчдад тухай бүр өгч ажилласан бөгөөд Монгол бичгийн сургалтыг байгууллагын Архив, албан хэргийн эрхлэгч 18 удаа зохион байгуулж, албан хаагчид тогтмол, бүрэн хамрагдсан. | |
| 3.3.5 | Жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль тогтоомжийг байгууллагынхаа хэмжээнд мөрдөн ажиллах | | 40:60 харьцаа холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх | Зөрчил гараагүй | Байгууллагын нийт ажилтны дунд аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд хүйсийн 40:60 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх бодлого, арга | Жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль тогтоомжийг байгууллагын хэмжээнд мөрдөн ажиллаж байна. Жендэрийн талаар гарсан зөрчил дутагдалгүй.<br>2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Жендерийн эрх тэгш байдлыг хангах зорилгоор Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалтад мэргэжилтэн Б.Төгөлдөржаргал, Ц.Амаржаргал нар хамрагдаж, сургалтын талаарх мэдээллийг албан хаагчдад өгсөн. | 100<br>100. |

69

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэмжээг хүний нөөцийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх | | |
| 3.4 | ЗОРИЛТ-3.4 Төрийн албаны хууль тогтоомж, бодлого, шийдвэр, стандартын хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, үр дүнг тайлагнах" | | | | | | 14. |
| 3.4.1 | Арга хэмжээ-1: Байгууллагын хүний нөөцийн асуудал, албан хаагчдын хөдөлмөрийн харилцаатай холбоотой захиргааны акт, гэрээ, дүрэм, журам, тушаал, шийдвэрийг боловсруулах, албажуулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах | | Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна. | | Хөдөлмөрийн харилцаатай холбоо хуулийн дагуу хэрэгжсэн байна. | Төрийн үйлчилгээний албан хаагчдын буюу Хүний нөөц, дотоод ажил хариуцсан ажилтан, Нягтлан бодогч, Архив, бичиг хэргийн эрхлэгч, Нярав, архивч нарын Хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулсан. Байгууллагын хэмжээнд хүний нөөцтэй холбоотой Б тушаал 18, бусад үйл ажиллагаатай холбоотой А тушаалын 54 төслийг боловсруулсан бөгөөд Баримт нягтлан шалгах комиссын ажиллах журмыг А/28, Албан хэрэг хөтлөлтийн журмыг А/56, Хөдөлмөрийн дотоод журмыг А/48 дугаар тушаалаар шинээр боловсруулж батлан ажиллалаа. | 100<br>100. |
| 3.4.2 | Арга хэмжээ-2: Хүний нөөцийн цахим систем, төрийн албан хаагчийн бүртгэл, хөдөлгөөн, холбогдох бичиг баримтын бүрдүүлэлт, хүний нөөцийн мэдээ, тайланг хууль тогтоомжийн дагуу хөтөлж, тайлагнах | | Төрийн албаны тухай хууль тогтоомж, стандартын хэрэгжилт хангагдсан байна. | | Хүний нөөцийн мэдээ, тайланг хууль тогтоомжийн дагуу хөтлөгдөж тайлагнасан байна. | Хүний нөөцийн удирдлага мэдээллийн цахим системд 2 албан хаагчийн мэдээллийг шинээр оруулж, 3 албан хаагчийн мэдээллийг өмнөх байгууллагаас татан авч, дутуу мэдээллийг оруулсан.<br>-Албан тушаалын нэршлийг өөрчлөх 12 удаа,<br>-Даатгуулагчийн төрөл өөрчлөх 15 удаа,<br>-Албан тушаалыг өөрчлөх 5 удаа,<br>-Цалингийн хэмжээ өөрчлөх 14 удаа<br>-Орон нутгийн нэмэгдлийг засварлах 12 удаа,<br>-Хоол унааны хөнгөлөлтийг өөрчлөх 12 удаа, нийт 70 удаагийн өөрчлөлт, хөдөлгөөнийг оруулан ажилласан. | 100<br>100- |
| 3.4.3 | Арга хэмжээ-3 Албан хаагчдын хувийн хэргийг | | Төрийн албаны тухай хууль тогтоомж, | | Албан хаагчдын хувийн хэрэг стандартын дагуу | Шинээр томилогдсон 4 албан хаагч, шилжиж ирсэн 2 албан хаагчийн хувийн хэргийг Төрийн албаны зөвлөлийн 2022 оны | 100<br>100. |

70

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтлөх, стандартын дагуу бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, хадгалах, тогтмол баяжуулах, мэдээллийн сан бүрдүүлэх | | стандартын хэрэгжилт хангагдсан байна. | | хөтлөгдөн, баяжигдсан байна. | 600 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын дагуу хөтөлж, шаардлагатай материалыг бүрдүүлэн, баяжилт хийж ажиллалаа. Мөн 4 албан хаагчийн чиглүүлэх сургалтын гэрчилгээний хуулбар болон сонгуулийн хороонд ажиллах үнэмлэхийн хуулбарыг албан хаагчдын хувийн хэрэгт хавсаргасан. | |
| 3.4.4 | Арга хэмжээ-4: Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эрх бүхий албан хаагчдад ёс зүйн хэмжээ, холбогдох хууль тогтоомжийг сахих талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх | | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг мөрдүүлсэн байна. | | Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байна. | Ёс зүйн дэд хороог албан хаагчдын саналыг үндэслэн А/30 дугаар тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд ёс зүйн дэд хорооны төлөвлөгөөг 13 арга хэмжээний хүрээнд боловсруулан батлуулж хэрэгжүүлэн ажилласан. Ёс зүйн дэд хорооноос 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдөр "Байгууллагын соёл, албан хаагчдын харилцаа хандлагын талаарх" сургалтыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын сэтгэл зүйч Б.Болдсайхантай хамтран зохион байгуулж, байгууллагын албан хаагчид бүрэн хамрагдсан. | 100<br>100 |
| 3.5 | ЗОРИЛТ-3.5: Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинийг дүгнэх, үнэлэх ажлыг зохион байгуулах, мэргэжил, арга зүйгээр хангах | | | | | | 15. |
| 3.5.1 | Арга хэмжээ-1: Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг тайлагнах ажлыг зохион байгуулах, мэргэжил, арга зүйгээр хангаж, | | Албан тушаалын тодорхойлолттой уялдсан, холбогдох журам, заавар, стандартад нийцсэн байна. | | Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, гүйцэтгэлийг хянаж ажиллана. | Байгууллагын 10 албан хаагч гүйцэтгэлийн төлөвлөгөөг албан тушаалын тодорхойлолттой уялдуулан боловсруулж албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэн байгууллагын төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам", Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар | 100<br>90. |

71

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналт тавих | | | | | -тушаалын-3-дугаар хавсралтаар батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ыг үндэслэн 6 зорилго, 21 зорилт, 75 арга хэмжээний хүрээнд боловсруулан батлуулан, хагас бүтэн жилээр биелэлтийг гаргаж ажилласан. | |
| 3.5.2 | Арга хэмжээ-2: Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах, нэгдсэн тайланг гаргах, үнэлгээ, дүгнэлтийн мөрөөр авах арга хэмжээг хэрэгжүүлэх | | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна. | | 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах, жилийн эцсийн тайланг гаргах, дүгнэх ажлыг зохион байгуулна. | Хагас жилээр 7 албан хаагчийн гүйцэтгэлийн үйл ажиллагааны үр дүнг Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх журам" -ын дагуу үнэлсэн.<br>Өмчийн ашиглалт, бүртгэл хариуцсан ахлах мэргэжилтэн -97,96<br>Өмчийн удирдлага, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн-95,52<br>Өмчийн удирдлага, төлөөлөл хариуцсан мэргэжилтэн-98,17<br>Ерөнхий нягтлан бодогч-99,38<br>Архив, бичиг хэргийн эрхлэгч-97,5<br>Хүний нөөц, дотоод ажил хариуцсан ажилтан-95,86<br>Нярав, архивч-99,23 буюу "маш сайн" үнэлэгдсэн байна.<br>Гүйцэтгэлийн тайланг үнэлж цаашид анхаарах зүйлсийг албан хаагч бүрээр танилцуулан, тайлангаа гаргахдаа оновчтой, тоо мэдээлэлтэй тодорхой бичих талаар зөвлөсөн. | 100<br>100 |
| 3.5.3 | Арга хэмжээ-3: Төрийн албан хаагчийн тэтгэмж, урамшуулал, үндсэн болон нэмэгдэл цалин хөлс, бусад зардал, сургалт, | | Тооцоо, судалгаанд үндэслэгдсэн, албан хаагчдын нийгмийн асуудлыг хууль тогтоомжийн дагуу | | 2025 оны төсвийн төсөлд санал боловсруулан хүргүүлнэ. | 2024 оны байдлаар шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх сургалтад хамруулахад 660,000 төгрөг, албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулахад 9,830,000 төгрөг, албан хаагчдын дархлааг дэмжих бүтээгдэхүүн олгоход 2,012,800 төгрөг, олон | 100<br>100. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөгжлийн асуудалтай холбоотой зардлын тооцоо, төсвийг тухайн жилийн төсвийн төсөлд тусгах санал боловсруулах | | шийдвэрлэх үндэслэл бүхий байна. | | | улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр болон шинэ жилийн баярыг тохиолдуулан албан хаагчдын хүүхдэд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд 1,080,000 төгрөг, 2 албан хаагчид 3 удаагийн 25,350,000 төгрөгийн буцалтгүй тусламж олгож, байгууллагын төсвөөс зарцуулсан байна.<br>Төрийн албан хаагчийн тэтгэмж, урамшуулал, үндсэн болон нэмэгдэл цалин хөлс, бусад зардал, сургалт, хөгжлийн асуудалтай холбоотой зардлыг 2025 оны төсөвт тусгасан. | |
| 3.5.4 | Арга хэмжээ-4:<br>Иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, албан бичгийг хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлэх | | Өргөдөл, гомдол албан бичгийг хууль тогтоомжийн дагуу хүрээнд хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | | Иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлыг журмын дагуу хугацаанд нь шийдвэрлэн ажиллана. | Тайлант хугацаанд байгууллагад ирсэн бичиг 407, явуулсан бичиг 1020, ирсэн өргөдөл хүсэлт 15 байна. 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр, 09 дүгээр сарын 26-ны өдөр, 11 дүгээр сарын 27-ны өдрүүдэд аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн мэдээлэл, төрийн цахим үйлчилгээний төв, иргэдтэй харилцах асуудал хариуцсан ахлах мэргэжилтэнд өргөдөл гомдлын тайланг 3 удаа хүргүүлсэн. Ирсэн албан бичгүүдийн хугацаанд и-оффис системээр хяналт тавьж, хариуг хугацаанд нь өгч ажилласан.<br>Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын дагуу хөтлөгдөж байна. | 100<br>90. |
| 3.5.6 | Арга хэмжээ-5:<br>Баримт бичгийн боловсруулалтыг журам, стандартад нийцүүлэн үйлдэж, тайлангийн жилд зохион бүрдүүлсэн ажлын баримтыг хөтлөх хэргийн | | Архив, албан хэрэг хөтлөлтийн журам, стандартыг мөрдөж ажилласан байна. | | Архив, албан хэрэг хөтлөлтийн журам, стандартыг мөрдөж ажилласан байна | Байгууллагын баримт нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг байгууллагын даргын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/28 дугаар тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна.<br>2024 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гарган баталсан.<br>Хөтлөх хэргийн жагсаалтын дагуу явуулсан бичгийн 7, ирсэн бичгийн 5, хүний нөөцийн 3 | 100<br>100. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэрийн жагсаалтын дагуу байгууллагын архивт хугацаанд нь бүртгэлээр хүлээлгэн өгөх | | | | | нийт 15 хадгаламжийн нэгжийг архивлан архивд хүлээлгэн өгсөн байна. | |
| 3.5.7 | И-оффис системийг байгууллагынхаа хэмжээнд бүрэн ашиглаж цаг хугацаа, цаас хэмнэх ажлыг хэрэгжүүлэх | | Ирсэн өргөдөл гомдол үүрэг даалгаврыг хугацаанд нь хэрэгжүүлэх | И-оффис системээр 2023 оны ирсэн бичиг 615, явуулсан бичиг 856, хүсэлт 217, Засаг даргын Шуурхайн үүрэг даалгаварын хэрэгжилтийг хангаж цаг хугацаа, цаас хэмнэн ажилласан байна. | Тухайн хугацаанд нь хэрэгжүүлэх | И-оффис системийн албан хэрэг хөтлөлтийн систем, бичиг төлөвлөлтийн систем, ажлын төлөвлөгөө тайлангийн систем, үүрэг даалгаврын систем, бодлогын баримт бичгийн системийг албан хаагч бүр чиг үүргийн дагуу тогтмол ашиглаж байна.<br>И-оффис системээр ирсэн бичиг 429, явуулсан бичиг 248, ирсэн өргөдөл хүсэлт 67 байна. Албан хаагчид мэдээлэл солилцоход и-оффис системийг бүрэн ашиглаж байна. | 100<br>100. |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго-5:<br>Нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандарт, монгол улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, стандартыг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 5.1 | ЗОРИЛТ-1: Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандарт, монгол улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, стандарт, заавраын дагуу хөтлөх | | | | | | -16. |
| 5.1.1 | Арга хэмжээ-1: Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль тогтоомж, бусад холбогдох дүрэм журмын хэрэгжилтийг байгууллагын хэмжээнд зохион байгуулах | Байгууллагын төсвөөр | Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх, бүртгэл хөтлөх, тайлагнах, ажлын байрны чиг үүрэгт хамаарах асуудлаар удирдлагыг | Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль тогтоомж, бусад холбогдох дүрэм журмын хэрэгжилтийг хангуулан байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд | Тайлант жилийн санхүүгийн үйл ажиллагааг хөтлөн явуулж, НББ-ийн үйлчилгээг цахим системээр гүйцэтгэж, эд хариуцагч нарт хяналт тавьж, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангаж ажиллана. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомж, холбогдох журам заавраын дагуу байгууллагын удирдлага болон албан хаагчдыг санхүүгийн мэдээллээр хангаж, батлагдсан төсвийн хүрээнд орлого, зарлагын гүйлгээг бүртгэн баталгаажуулж санхүүгийн зөрчил дутагдалгүй ажилласан. | 100<br>100. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шаардлагатай мэдээллээр хангах. | мөрдөж ажилласан. | | | |
| 5.1.2 | Арга хэмжээ-2: Олон улсын стандарт, эрх бүхий байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, зааврыг баримтлан байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх | | УСНББОУСтандарт, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Санхүүгийн тайлангийн тодруулга бэлтгэх журам"-ын дагуу байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулах. | Олон улсын стандарт, эрх бүхий байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, зааврыг баримтлан байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл хөтлөлтийг хийж гүйцэтгэсэн | Холбогдох хууль тогтоомж, заавар журмын дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтлөсөн байх | Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд УСНББОУС болон Орхон аймгийн Засаг даргын 2023 оны А/255 дугаар захирамжаар батлагдсан "Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөн ажиллаж байна. | 100 100 |
| 5.1.3 | Арга хэмжээ-3: Орон нутгийн өмчийг эзэмшиж, ашиглаж буй этгээдтэй гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих | | Орон нутгийн өмчийг эзэмшиж, ашиглаж буй этгээдтэй байгуулах өмч ашиглалтын гэрээтэй танилцах, гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих | Тайлант хугацаанд орон нутгийн өмчийг ашиглагч төрийн 9, төрийн бус 3, хувийн хэвшлийн 3 байгууллагатай өмч ашиглалтын болон эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулан хэрэгжилтэд | Орон нутгийн өмчийг эзэмшиж, ашиглаж буй этгээдтэй өмч ашиглалтын гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. | Орон нутгийн өмчийн 12 барилга байгууламжид 12 иргэн, 12 аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллага ашиглалтын гэрээгээр үйл ажиллагаа явуулж байна. Мөн 8,8 сая төгрөгийн 14 ширхэг тоног төхөөрөмж, 2.340,4 сая төгрөгийн 21 тээврийн хэрэгслийг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа иргэн, байгууллагатай эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээг байгуулан, эд хөрөнгийн хагас бүтэн жилийн тооллогод хамруулж, хөрөнгийн ашиглалтын байдалд хяналт тавин ажиллаж байна. | 100. 100 |

75

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хяналт тавьж ажилласан байна. | | | |
| 5.1.4 | Арга хэмжээ-4: Байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах, Газрын дарга болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах | | Үндсэн болон нэмэлт дансны төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд тайлагнаж, Газрын дарга болон бусад санхүүгийн тайлан хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулж, батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулж, зориулалтын дагуу зарцуулж зөрчилгүй ажиллах | Тайлант онд нийт 566.3 сая төгрөгийн санхүүжилт авч төсвийн хуваарийн дагуу зориулалт тус бүрээр зарцуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд сар бүр гүйцэтгэлийн мэдээ, улирлын санхүүгийн тайланг гарган нэгтгүүлж, санхүүгийн холбогдох мэдээллийг мэдээллийн самбараар болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан. Тайлант хугацаанд мэдээллээгүй болон хугацаа хоцроож | Байгууллагын урсгал зардлын үйл ажиллагаанд зарцуулсан төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг сар бүр, хагас жилээр Нэмэлт санхүүжилтийн дансны тайланг хагас, бүтэн жилээр тайлагнаж, хэрэглэгчдийг санхүүгийн мэдээллээр хангасан байх | Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гарган Санхүү төрийн сангийн хэлтсийн холбогдох мэргэжилтэнд хүргүүлж, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулдаг. Нэмэлт санхүүжилтийн дансаар Монгол улсын Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар Орхон аймагт баригдсан 315 айлын түрээсийн орон сууцны төлбөрийг хүлээн авч төвлөрүүлэн ажилладаг. Тайлант хугацаанд 1.897,4 сая төгрөгийн орлогыг хүлээн авч, 1.884,0 сая төгрөгийг Монгол улсын Хөгжлийн банканд шилжүүлсэн. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа доголдолгүй хэвийн явагдаж байгаа ба тайлант хугацаанд үүссэн болон он дамжсан өр, авлага байхгүй. | 100. 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мэдээлсэн зөрчил байхгүй болно. | | | |
| 5.1.5 | Арга хэмжээ-5: Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангахад дэмжлэг үзүүлэх. | 5200,0 мян | Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангагдах | | Батлагдсан төсвийн хүрээнд хууль тогтоомжийн дагуу албан хаагчдад үзүүлэх дэмжлэг туслалцааг үзүүлэх, нийгмийн баталгааг хангах | Албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулж 36,5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 39,3 сая төгрөгийн тавилга эд хогшил, мөн өдөр тутмын хэвийн ажиллагааг хангаж ажиллахад шаардлагатай бичиг хэрэг, аж ахуй, барилгын засварын материалд 22,3 сая төгрөгийн худалдан авалт хийж зарцуулсан. Албан хаагчдын дархлааг дэмжин 2012,8 мянган төгрөгийн дархлаа дэмжих бүтээгдэхүүн олгосон. Мөн олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, шинэ жилийн баярыг тохиолдуулан албан хаагчдын хүүхдүүдэд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж 1080,0 мянган төгрөгийн бэлэг, ар гэрийн гачигдал гарсан 2 албан хаагчид 3 удаагийн 25,350.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламжийг тус тус олгосон. | 100 100 |
| 5.2 | ЗОРИЛТ-2: Байгууллагын төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах арга хэмжээг хариуцан гүйцэтгэх | | | | | | 17 |
| 5.2.1 | Арга хэмжээ-1: Байгууллагын төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах арга хэмжээг хариуцан гүйцэтгэх, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээ хийсэн тохиолдолд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдлийг эрх бүхий албан тушаалтанд файлаар болон цаасаар хүргүүлэх, | | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан тухай бүр 9, сар бүр 4, хагас жилд 4, бүтэн жилээр 11, нийт 28 талбарт санхүүгийн мэдээллийг үнэн зөв, иж бүрэн оруулж, хуулийн хугацаанд | Санхүүгийн мэдээллийг үнэн зөв, иж бүрэн оруулж, шилэн дансны сайтад хуулийн хугацаанд илгээх, байгууллагын мэдээллийн самбарт ил тод байршуулах, мэдээллийг тухай бүр шилэн дансны сайтад илгээж, мэдээллийн самбарт ил тод | Шилэн дансны цахим хуудсанд тухай бүр мэдээлэх 9, сар бүр мэдээлэх 4, жил бүр мэдээлэх 3 талбарт санхүүгийн мэдээллийг хугацаанд нь байршуулж, ил тод болгож хэвшсэн. Тайлант хугацаанд мэдээлэх ёстой 148 талбарт санхүүгийн мэдээллийг хугацаанд нь мэдээлж ажилласан.<br>Тайлант хугацаанд газрын даргын хамт 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 7 гүйлгээнд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдлийг гарган, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тухай бүр ил тод, нээлттэй байршуулсан. | 98,3 98,3 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийг шилэн дансанд байршуулах | | бөглөх, хэрэгжүүлэх | илгээж ил тод болгосон. Мөн байгууллагын мэдээллийн самбарт тухай бүр байршуулсан. Тайлант хугацаанд 5 сая төгрөгөөс дээш орлогын 5, зарлагын 9 гүйлгээ гарсан ба тухай бүр шилэн дансанд байршуулж ил тод болгосон. | байршуулах | | |
| 5.2.2 | Арга хэмжээ-2: Байгууллагын төсөв, санхүүгийн гүйцэтгэл, аудит хийлгэсэн жилийн санхүүгийн тайлан болон түүний хураангуйг аудиторын дүгнэлтийн хамт мэдээллийн самбар болон шилэн дансны сайтад байршуулж, ил тод байдлыг хангах | | Байгууллагын төсөв санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдал хангагдсан байх | Төрийн аудитын хяналт шалгалтад тайлант жилийн санхүүгийн баримтаа хүргүүлсэн ба хуулийн хугацаанд шалгалт хийгдэж гарсан дүгнэлтийг ил тод байршуулна. | Төрийн аудитын газарт хүргүүлж, аудиторын дүгнэлийг гаргуулсан байх, Аудит хийлгэсэн жилийн санхүүгийн тайлан, дүгнэлтийг шилэн дансны сайтад болон мэдээллийн самбарт байршуулж ил тод байдлыг хангах | Байгууллагын 2023 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж, Төрийн аудитын байгууллагад хүргүүлэн, аудитын тайлан, дүгнэлтийг хүлээн авч, зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэн хугацаанд нь хүргүүлж ажилласан. Аудитын тайлангаар өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчид байгууллагын дотоод журмын дагуу тэтгэмж давхардуулан олгосон, анхан шатны баримтын бүрдэл дутуу, худалдан авч орлогоор бүртгэсэн бараа, ажил үйлчилгээний тоо хэмжээ, үнийн дүнг цахим төлбөрийн баримтад нийт дүнгээр бүртгэсэн зөрчил дээр 3 зөвлөмж авч тайлант онд зөрчлийг арилган, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажилласан. | 100. 100 |
| 5.3 | ЗОРИЛТ-3: Эд хөрөнгө болон төлбөр тооцооны тооллого хийн, үр дүнг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах | | | | | | 18. |
| 5.3.1 | Арга хэмжээ-1: Өмч хөрөнгийн ашиглалт, | | Байгууллагын өмч хөрөнгийн бүртгэлээрх | Хөрөнгийн төрөл тус бүрээр | Өмч хөрөнгийг эд хариуцагт нарт картаар | Хөрөнгийн тооллогыг жилд 2 удаа зохион байгуулан явуулж, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг холбогдох баримтад үндэслэн | 100. 100 |

78

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамгаалалтыг сайжруулан бүртгэлээр хяналт тавих | | хяналтыг сайжруулж, хөрөнгийг ТӨ, ТӨХ маягт тайлан болон Төрийн өмчийн хорооны мэдээлжүүлэх системд данс бүрээр хөрвүүлэн бүрэн оруулж баталгаажуулах | эзэмшигчийн гар картыг хөтөлж, эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр зохион байгуулан явуулж, хөрөнгийн хөдлөл өөрчлөлт орсон тухай бүр картыг шинэчилэн ажиллаж хэвшсэн. Мөн төрийн өмчийн тооллогын цахим системд бүртгэлийг давхар хөтөлж байна. | эзэмшүүлж, жилд 2-с доошгүй удаа тайлан балансаар тулгаж, хөрөнгийн ашиглалтыг сайжруулж хяналт тавих, ТӨ, ТӨХ маягтуудыг данс бүрээр нэгтгэн үнэн зөв хөтлөх | данс бүртгэлийг хөтөлдөг. Байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй газар, барилга, нийтийн эзэмшлийн хөрөнгийг тулган баталгаажуулалт хийж, ашиглалтын байдлыг нягталсан. Аймгийн Засаг даргад хүргүүлэн 2024 оны А/527 дугаар, 2024 оны А/411 дүгээр захирамжаар захирамжаар Даваат багийн албан конторын барилгын 6104300729 нэгж талбарын дугаартай, 1625 м2 газар, Баянцагаан багийн албан контор, халуун усны барилгын 6102101344 нэгж талбарын дугаартай, 2158 м2 газрыг Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газарт шилжүүлсэн. Мөн нийтийн эзэмшил дансанд бүртгэх ёстой 62,9 сая төгрөгийн "Захиргааны 4-р байр Гадна тохижилтын ажлын 1-р хэсэг", 48,2 сая төгрөгийн "Оюуны спортын ордны гадна талбайн тохижилт"-ын хөрөнгө барилга дансанд бүртгэлтэй байгааг данс хооронд шилжүүлэх талаар тооллогын комиссын дүгнэлт гаргаж хөрөнгийг данс хооронд шилжүүлж алдааг засах саналыг хүргүүлсэн. | |
| 5.3.2 | Арга хэмжээ-2: Газрын өмч хөрөнгийг фото зураг, марк, код, сериал дугаар, үзүүлэлтээр нь нэг бүрчлэн бүртгэлжүүлэх | | Төрийн өмчийн хорооны мэдээлжүүлэх системд өөрчлөлтийн мэдээллийг оруулж баталгаажуулах, өмч хөрөнгийг фото зураг, марк, код, сериал дугаар, үзүүлэлтээр гаргах | Тайлант хугацаанд холбогдох шийдвэрийг үндэслэн 3 нэр төрлийн 2074,6 сая төгрөгийн 14 ширхэг тээврийн хэрэгсэл, 63,2 сая төгрөгийн барилгын засвар, 21,1 сая төгрөгийн 8 ширхэг тоног | Байгууллагын тайлан балансад бүртгэлтэй байгаа хөрөнгө болон шинээр орлого авсан хөрөнгийн марк, код, сирал дугаар, үзүүлэлтийн үнэн зөвийг тулгаж, фото зургаар баталгаажуулж эд хариуцагч нарт хүлээлгэн өгөх, хөрөнгийн | Төрийн өмчийн тооллогын системд 2023 оны жилийн эцсийн байдлаар хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн мэдээллийг бүрэн оруулж, хариуцсан мэргэжилтэнд хянуулж баталгаажуулсан. Санхүүгийн тооцооллын Си-Ти-Эс системд мөн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг бүртгэж, хөрөнгө тус бүрийг QR код бүхий таних тэмдгээр тэмдэгжүүлсэн. Хөрөнгө ашиглагч төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан хаагчидтай "Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ"-г байгуулан, албан ажлын хэрэгцээнд ашиглаж байгаа хөрөнгөд "Эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл"-ийг хөтөлж, фото зургаар | 100. 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | төхөөрөмжийг орлогод, 2397,3 сая төгрөгийн дусаагүй барилга, 1,1 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 12,5 сая төгрөгийн 16 ширхэг тоног төхөөрөмж, 2,6 сая төгрөгийн 16 ширхэг тавилга эд хогшлыг зарлагад холбогдох шийдвэрийг үндэслэн данс бүртгэлд тусгасан байна. | тооллогыг жилд 2 удаа зохион байгуулан явуулах | баталгаажуулан, хөрөнгийн ашиглалтын байдалд хяналт тавин ажилладаг. Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын шийдвэрээр шилжүүлэн авсан 525,7 сая төгрөг, худалдан авсан 42,2 сая төгрөгийн хөрөнгийг орлогод, шилжүүлсэн 4174,5 сая төгрөгийг зарлага дансанд бүртгэж, холбогдох байгууллагуудтай үндсэн хөрөнгө шилжүүлэх, хүлээн авах актыг үйлдэж баталгаажуулж ажиллалаа. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго-6: Байгууллагын шийдвэр, журам, дүрэм, хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ, түрээсийн болон бусад гэрээ зэрэг захиргааны шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянаж, хууль зүйд нийцүүлэх** | | | | | | | 19. |
| 6.1 | ЗОРИЛТ-1: Байгууллагын шийдвэр, журам, дүрэм, хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ, түрээсийн болон бусад гэрээ зэрэг захиргааны шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянаж, хууль зүйд нийцүүлэх | | | | | | |
| 6.1.1 | Арга хэмжээ-1: Хууль тогтоомж, бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, тогтоол, шийдвэр, журам, дүрэм, аргачлал, заавар зэрэг баримт бичгийн санал, төсөл боловсруулах | | Хууль, эрх зүй, холбогдох журам, шаардлагад нийцсэн, үндэслэл бүхий байна. | - | Хууль, эрх зүй, холбогдох журам, шаардлагад нийцсэн санал, төсөл боловсруулна. | Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй баримт бичиг болон гарж буй шийдвэр, газрын даргын тушаал, орон нутгийн өмчит байгууллагуудын дүрэм, журам болон түрээс, бараа, үйлчилгээ нийлүүлэх гэрээ зэргийн төслийг боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах 83 мэдэгдэл аймгийн Засаг даргын албан тоотоор ирсэн. Мэдэгдлийн дагуу бараа худалдан авах гэрээг шалгарсан | 100. 100 |

87

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагуудтай байгуулж, гэрээний биелэлтэд хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд 20 гэрээг сунгасан. Байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчидтай холбоотой А тушаал 54, Б тушаал 18, нийт 72 тушаал гарган ажиллалаа. | |
| 6.1.2 | Арга хэмжээ-2: Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмын төсөл боловсруулах, батлуулж, мөрдүүлэх | | Батлагдсан дүрэм, журмыг мөрдөж хэвшсэн байна. | - | Хуулийн дагуу байгууллагад мөрдөгдөх дүрэм, журмыг боловсруулан, батлуулна. | Байгууллагын даргын 2024 оны А/48 дугаар тушаалаар "Байгууллагын дотоод журам", 2024 оны А/28 дугаар тушаалаар "Баримт нягтлан шалгах комиссын ажиллах дүрэм", 2024 оны А/56 дугаар тушаалаар "Албан хэрэг хөтлөлтийн журам"-ыг батлуулж, албан хаагчид мөрдөн ажиллаж байна. | 100<br>100. |
| 6.1.3 | Арга хэмжээ-3: Хууль хяналтын байгууллагад хянагдаж буй хэрэг, маргаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн эрх, үүргийг хэрэгжүүлж оролцох | | Итгэмжлэлээр олгогдсон эрх, үүргийн хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцоно. | - | Итгэмжлэлээр олгогдсон эрх, үүргийн хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцоно. | Орон нутгийн өмчийн нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй Говил багт байрлах 8 айлын орон сууцны байрны өмчлөлийн асуудлаар "Эрдэнэт авто зам" ХХК-ийн гаргасан нэхэмжлэлтэй Захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралд гуравдагч этгээдийн эрх, үүргийн дагуу Орхон аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүх хурал, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүр хуралд оролцсон. | 100<br>100. |
| 6.1.4 | Арга хэмжээ-4: Хууль, шүүхийн байгууллагаас шаардсан нотлох баримт, тайлбар, мэдээллийг судалж, боловсруулах, бүрдүүлэх, танилцуулах, хүргүүлэх | | Хуульд нийцсэн, үндэслэл бүхий, үнэн зөв мэдээлэл хүргүүлсэн байна. | - | Хуулийн дагуу нотлох баримт, тайлбар мэдээллийг хүргүүлнэ. | Орхон аймаг дахь сум дундын Иргэний болон Захиргааны хэргийн шүүхийн 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 352 тоот албан бичгээр ирүүлсэн иргэн Д.Баярцэцэгийн нэхэмжлэлтэй "Орон сууцны өмчлөгчөөр тогтоолгох тухай", 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 882 тоот албан бичгээр ирүүлсэн "Маргад тамир" ХХК-ийн нэхэмжлэлтэй "Залуучуудын соёлын төвийн дуусаагүй барилга"-ын дуудлагын худалдааны материал, 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 960 тоот албан бичгээр ирүүлсэн иргэн Б.Баяр-Ундралмаагийн нэхэмжлэлтэй "Говил баг, Илгээлтийн 3-9 тоот байрны жинхэнэ өмчлөгчөөр тогтоолгох тухай" | 100<br>100 |

9

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | захирамжуудад хариуг заасан хугацаанд нь албан бичгээр хүргүүлсэн. | |
| 6.2 | ЗОРИЛТ-2: Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажил, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг үйл ажиллагааг зохион байгуулах | | | | | | 20. |
| 6.2.1 | Арга хэмжээ-1: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлого, чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад чиглэсэн сургалт зохион байгуулах, хууль тогтоомжийг сурталчлан таниулах, тайлагнах | | Төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан байна. | - | Хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулна. | Байгууллагын албан хаагчдад Авлигын эсрэг тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн талаар сургалт зохион байгуулсан. | 100<br>100 |
| 6.2.2 | Арга хэмжээ-2: Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, харьяа орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мэдүүлэг бүрдүүлэлттэй холбоотой асуудлаар арга зүйн дэмжлэг | | Хуульд нийцсэн үндэслэл бүхий зөвлөгөө, мэдээллээр хангасан байна. | - | Хуульд нийцсэн үндэслэл бүхий зөвлөгөө, мэдээллээр хангасан байна. | Байгууллагын албан хаагчдад Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хөрөнгө орлогын мэдүүлэг бүрдүүлэлтэй холбоотой асуудлаар арга зүйн зөвлөгөө өгсөн. Мөн 2024 онд шинээр томилогдсон 5 албан хаагч болон байгууллагын нийт албан хаагчдад Авлигын эсрэг тухай хуулийн талаар сургалт зохион байгуулсан. Байгууллагын 2024 оны Авлигын эсрэг төлөвлөгөөг боловсруулж баталсан. www.umch-erdenet.mn цахим хаягийг нээж түүн дээр Авлигатай тэмцэх газраас гаргасан мэдээ, мэдээлэл, Авлига, ашиг сонирхлын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай зөвлөмж, шторк зэргийг тогтмол байршуулан ажилласан. Аймаг, нийслэл, сум, дүүргийн орон нутгийн | 100<br>100. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үзүүлж, зөвлөгөө, мэдээллээр хангах | | | | | сонгуулийн үр дүнгээр өөрчлөгдсөн орон нутгийн өмчит "Жаргалант ус, дулаан түгээх сүлжээ" ОНӨХК, "Хот байгуулалт барилга, захиалагчийн алба" ОНӨААТҮГ, Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар, Хот тохижуулах газрын удирдах албан тушаалтнуудад хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг гаргахад дэмжлэг туслалцаа үзүүлэн ажилласан. | |
| 6.2.3 | Арга хэмжээ-3: Агентлагийн удирдлага, холбогдох эрх бүхий албан тушаалтан , албан хаагчид болон иргэн, хуулийн этгээдийг хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, арга зүйгээр хангах | | Хуульд нийцсэн, үндэслэл бүхий зөвлөгөө, мэдээллээр хангасан байна. | - | Хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулна. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барааны гэрээ байгуулах 59 байгууллагад давхардсан тоогоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орж буй 258 айлын орон сууцны байранд орох хүсэлт гаргасан 1257 орчим иргэнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлагдсан 2023 оны 17/06 дугаар тогтоолоор батлагдсан "Орлогод нийцсэн орон сууцны журам" болон холбогдох бусад хууль тогтоомжийн талаар зөвлөгөө мэдээллийг тогтмол өгч ажиллалаа. | 100<br>100 |
| 6.2.4 | Арга хэмжээ-4: Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дотоод аудит, хяналтыг хэрэгжүүлэхэд мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, аргачлалыг албан хаагчдад сурталчлан таниулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах. | | Албан хаагчид холбогдох хууль тогтоомж, журам, аргачлалын талаар ойлголт, мэдээлэлтэй болсон байна. | - | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дотоод аудит, хяналтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дотоод аудит, дотоод хяналт хийхэд мөрдөж буй Засгийн газрын 206 дугаар тогтоол, бусад дүрэм журмыг албан хаагчдад танилцуулсан.<br>Мөн Орон нутгийн өмчит төсвийн 9 байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийлээ. Хяналт-шинжилгээний үр дүнд байгууллагуудын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагаа хангалтгүй, тооллогын комисс үр дүн муутай ажилласан, илүүдэлтэй, ашиглагдахгүй, дутсан, маргаантай хөрөнгийн бүртгэл | 100<br>100. |

83

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөтлөөгүй зэрэг алдаа дутагдал гарлаа. Дээрх асуудлаар цаашид хэрхэн ажиллах талаар журам, дүрмийн дагуу заавар зөвлөгөө өгч ажиллалаа. | |
| 6.2.5 | Арга хэмжээ-5: Тухайн жилд хийх, хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах | | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дотоод аудит, хяналтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | - | Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг боловсруулан, батлуулах, хэрэгжилтийг ханган ажиллана. | Байгууллагын 2024 оны хяналт-шинжилгээ үнэлгээний төлөвлөгөөг боловсруулж баталсан. Төлөвлөгөөний дагуу орон нутгийн өмчит байгууллагуудын санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг "Гэр бүлийн ордон" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны орлого нь тогтвортой бус, орлогоороо өөрийгөө бүрэн санхүүжүүлэх чадваргүй. 2020-2023 онуудад 45,2-89,5 сая төгрөгийн өр төлбөртэй, 17,2-23,6 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж байгаа тул цаашид компанийн хэлбэрт шилжүүлэх, "Их шүтээн цогцолбор" ОНӨААТҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны жилийн орлого нь 1.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 2020-2023 онуудад 49,9-68,9 сая төгрөгийн зардлын санхүүжилт авсан, 88,9-168,6 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж байгаа тул нэгтгэн зохион байгуулах, татан буулгах саналыг гаргаж аймгийн Засаг дарга болон иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргад танилцуулсан. | 100<br>100. |
| 6.2.6 | Арга хэмжээ-6: Аймгийн хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрүүдийгийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээ, зорилтот түвшний хэрэгжилтэд хяналт- | | Холбогдох журам, аргачлалын дагуу үнэн бодитой хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдсэн байна. | - | Бодлогын баримт бичигт хяналт тавих ажлыг зохион байгуулна. | Монгол Улсын Засгийн газрын 6 тогтоолын 10 заалт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөний 2 зорилтын 2 заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 23 тогтоолын 26 заалтын хэрэгжилтийг сар бүр гаргаж, биелэлтийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст и-оффис системээр хүргүүлэн ажиллаж байна. | 100<br>90 |

84

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шинжилгээ, үнэлгээ хийх, дүнг тайлагнах, танилцуулах, зөвлөмж өгөх | | | | | | |
| 6.2.7 | Арга хэмжээ-7: Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулах, тайлагнах, мэдээлэх | | Холбогдох журам, аргачлалын дагуу үнэн бодитой хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдсэн байна. | - | Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна. | Аймгийн Засаг даргаас иргүүлсэн 01/1674 дугаартай 2023 оны үйл ажиллагаанд хийгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн дагуу албан хаагчдад 16 үзүүлэлтээс үнэлэгдсэн оноог танилцуулж, Хууль, тогтоомж Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт, аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэрийн биелэлт, Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал авсан арга хэмжээ, и-оффис систем ашиглалтын байдал, аймгийн Засаг даргаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг тайлагнахдаа оновчтой, тоо хэмжээг үнэн бодитой гаргахад анхаарч ажиллах үүрэг даалгавар өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. | 90<br>100 |
| 8.3 | ЗОРИЛТ-3: Байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд дотоод хяналт, аудитын үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, зөрчил, дутагдлыг арилгуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулалтаар хангах, үр дүнг тайлагнах | | | | | | 4. |
| 8.3.1 | Арга хэмжээ-1: Тухайн жилд дотоод аудит, дотоод хяналт хийх чиглэлийг тодорхойлж, төлөвлөгөө боловсруулан батлуулах, хэрэгжилтийг тайлагнах | | Холбогдох хууль, журмын хэрэгжилт хангагдана. | - | Байгууллагын дотоод аудит, дотоод хяналтын ажлыг зохион байгуулна. | 2024 онд хийх дотоод аудит, дотоод хяналт хийх ажлын төлөвлөгөөг жилийн ажлын төлөвлөгөөнд тусгаж төлөвлөгөөний дагуу Орон нутгийн өмчит байгууллагууд болон Төрийн өмчит байгууллагуудад Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай хамтран хяналт шалгалт хийж, байгууллагуудад зөвлөгөө, мэдээллийг өгч ажилласан. Мөн байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн хагас жилийн тооллогыг 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/32 дугаар тушаалаар, жилийн эцсийн тооллогыг 2024 оны 11 дүгээр сарын 01-ний А/52 дугаар тушаалаар зохион байгуулан ажилласан. Тооллогоор ямар | 100<br>100. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэгэн зөрчил дутагдал илрээгүй. | |
| 8.3.2 | Арга хэмжээ-2: Дотоод хяналтын үр дүнгээр гарсан зөрчил, дутагдлын талаар цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих | | Хуульд нийцсэн байна. | - | Дотоод хяналтын үр дүнгээр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | Орон нутгийн өмчит соёлын салбарын байгууллагуудад эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтын чиглэлээр төлөвлөгөөт бус 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс 11 дүгээр сарын 28-ны хооронд Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газартай хамтаар хийсэн. Байгууллагуудад шаардлагатай мэдээ, мэдээлэл, зөвлөмжийг тухай бүрд нь өгч ажилласан. | 100 100 |
| 8.3.3 | Арга хэмжээ-3: Төлөвлөгөөт бус аудит, хяналтыг тухай бүр хэрэгжүүлж, тайлагнах, авах арга хэмжээний санал боловсруулах, танилцуулах | | Зөрчил, доголдлыг арилгасан байна. | - | Төлөвлөгөөт бус аудит, хяналтын ажлыг зохион байгуулан ажиллана. | Төлөвлөгөөт бус аудит, хяналтыг байгууллагын хэмжээнд хийх шаардлагагүй байна. Орхон аймаг дахь Төрийн аудитын газраас 2024 оны 09 дүгээр сард төлөвлөгөөт бус шалгалт хийсэн бөгөөд тус шалгалтаар ямар нэгэн зөрчил дутагдал илрээгүй. | 100 100 |
| 8.3.4 | Арга хэмжээ-4: Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн талаар хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг хагас жил тутамд авах, дүнг нэгтгэн боловсруулах, тайлагнах, мэдээлэх, цаашид авах арга хэмжээг тодорхойлох, санал зөвлөмж боловсруулах | | Иргэд, олон нийтийн сэтгэл ханамж дээшилсэн байна. | - | Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг авч, үнэлэлт, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулна. | Байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг 2024 оны 09 дүгээр сард зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөр 8 асуулт бүхий санал хүсэлтийн хуудсаар авсан ба нийт 65 иргэнээс судалгаа авсан. Байгууллага, албан хаагчидтай холбоотой санал, гомдол гаргаагүй. | 100 100. |

| Д/д | Зорилт / Үнэлгээ | Бүгд | Гүйцэтгэлийн зорилт - 1 | Гүйцэтгэлийн зорилт - 2 | Гүйцэтгэлийн зорилт - 3 | Гүйцэтгэлийн зорилт - 4 | Гүйцэтгэлийн зорилт - 5 | Гүйцэтгэлийн зорилт - 6 | Гүйцэтгэлийн зорилт - 7 | Гүйцэтгэлийн зорилт - 8 | Гүйцэтгэлийн зорилт - 9 | Гүйцэтгэлийн зорилт - 10 | Гүйцэтгэлийн зорилт - 11 | Гүйцэтгэлийн зорилт - 12 | Гүйцэтгэлийн зорилт - 13 | Гүйцэтгэлийн зорилт - 14 | Гүйцэтгэлийн зорилт - 15 | Гүйцэтгэлийн зорилт - 16 | Гүйцэтгэлийн зорилт - 17 | Гүйцэтгэлийн зорилт - 18 | Гүйцэтгэлийн зорилт - 19 | Гүйцэтгэлийн зорилт - 20 | Гүйцэтгэлийн зорилт - 21 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Арга хэмжээний тоо | 75 | 5 | 2 | 1 | 4 | 3 | 5 | 1 | 2 | 2 | 4 | 3 | 4 | 5 | 4 | 6 | 5 | 2 | 2 | 4 | 7 | 4 |
| 2 | 6.2.1 буюу 100% ба түүнээс дээш | 68 | 4 | 2 | 1 | 3 | 2 | 3 | 1 | 2 | 2 | 4 | 2 | 4 | 5 | 4 | 6 | 5 | 1 | 2 | 4 | 7 | 4 |
| | 6.2.2 үүнээс 70.0% | 7 | 1 | | | 1 | 1 | 2 | | | | | 1 | | | | | | 1 | | | | |
| | 6.2.2 үүнээс 63.0% | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | 6.2.2 үүнээс 50.0% | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | 6.2.2 үүнээс 30.0% | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Ерөнхий үнэлгээ, хувь | | 97.2% буюу 4.86 оноо | 94% буюу 4.7 оноо | 100% буюу 5 оноо | 100% буюу 5 оноо | 92.5% буюу 4.63 оноо | 90% буюу 4.5 оноо | 88% буюу 4.4 оноо | 100% буюу 5 оноо | 100% буюу 5 оноо | 100% буюу 5 оноо | 100% буюу 5 оноо | 90% буюу 4.5 оноо | 100% буюу 5 оноо | 100% буюу 5 оноо | 100% буюу 5 оноо | 100% буюу 5 оноо | 100% буюу 5 оноо | 85% буюу 4.25 оноо | 100% буюу 5 оноо | 100% буюу 5 оноо | 100% буюу 5 оноо | 100% буюу 5 оноо |

-oOo-